

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-24
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	25-68
<hr/>	
1.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал	26-31
2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	31-32
3.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	32-67

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
4 дүгээр сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ариунзаяа, Ж.Баясгалан, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Б.Хэрлэн;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, М.Сарнай;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ц.Мөнхтуяа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт орсон “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг нам, эвслийн бүлгүүдээс Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг ирүүлээгүй тул хойшлуулах горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 4

Бүгд: 17

76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээрт орсон Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 3

Бүгд: 17

82.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, Б.Мажигсүрэн, референт Б.Энхмаа нар байлцав.

Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн нэрийг дэвшүүлснийг Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Найдалаа нар үг хэлэв.

Л.Энхнасан: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 1
Бүгд: 17
94.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун, “RMC үр шилжүүлэн суулгах үндэсний төв”-ийн эмч Э.Одхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Энхмаа нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Н.Алтаншагай, О.Саранчулуун нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Энхнасан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ж.Баясгалан, Л.Энхнасан, Х.Болормаа, Д.Рэгдэл, У.Отгонбаяр, М.Сарнай, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Хуулийн төслийн нэрийн “ЭРХТЭН, ЭД, ЭС” гэсний өмнө “ХҮНИЙ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	18
Бүгд:	18

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнөх “хүний” гэснийг хасаж, 4.1.2 дахь заалтын “бөгөөд гэрлэгчид, төрлийн хүн, садангийн хүн, хүргэн, бэр гэсэн дарааллаар сонгогдсон хүнийг” гэснийг “, хүргэн, бэрийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.3.“амьгүй донор” гэж тархины үйл ажиллагаа бүрэн, эргэшгүй алдагдсан, тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэл нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгахаар авч болох донорыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар, Д.Бум-Очир нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг “эсхүл” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “эсийг шилжүүлэн суулгах” гэсний өмнө “үүдэл” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6

Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.“реципиент эмнэлэг” гэж бүтцэд нь төрөлжсөн тасаг, мэргэжлийн багтай Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.8.“донор эмнэлэг” гэж амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.11.“био банк” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор авсан эд, эсийг хадгалах тусгай зориулалтын санг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.17 дахь заалтыг хасах:

“4.1.12.“эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлгийн нөхцөлд донорыг илрүүлэх, эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, шилжүүлэн суулгах болон мэс заслын дараах эмчилгээ, хяналт хийх эмнэлгийн тусламж, үйлчилгээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.17 дахь заалт нэмэх:

“4.1.17.“сорьц” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор хүнээс авсан цус, эс, эд, эрхтний хэсгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.18 дахь заалт нэмэх:

“4.1.18.“хүйн эд” гэж нярайн хүй таслагдсаны дараа ихэстэй залгаа хэсгээс тайран авсан хүйн судсан багцыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.19 дэх заалт нэмэх:

“4.1.19.“үндэсний хүлээх жагсаалт” гэж эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийг эрхтэн, эд, эс, цусны бүлгээр ангилан, эмнэл зүйн үнэлгээ, шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн бүртгэсэн жагсаалтыг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сайн дурын,” гэсний дараа “аливаа дарамт шахалт, бусдын нөлөөнд автахгүй” гэж нэмж, мөн зүйлийн 5.1.6 заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хоёрдугаар бүлгийн гарчгийн “ДОНОРЫГ СОНГОХ” гэснийг “ДОНОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагаас” гэж нэмж, мөн заалтын “холбогдох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагаас” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “холбогдох журам, зааврын дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “, хүүхэд” гэснийг “гаргах бөгөөд, хүүхэд, эрх зүйн бүрэн чадамжгүй иргэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж нэмж, 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасаж, мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж нэмж, 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасаж, мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсрол харгалзахгүйгээр иргэн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалуулах” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр хүн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалах” гэж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “хангах” гэснийг “сайжруулах” гэж өөрчилж, мөн заалтын “тусламж, үйлчилгээг” гэсний өмнө “эрүүл мэндийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтын “сайн дурын үндсэн дээр” гэснийг “сайн дураар” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэцийн эмгэггүй” гэсний өмнө “хөгжлийн бэрхшээлгүй хүн болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулан эрхтэн, эд, эсээ өгөхдөө” гэнийг, мөн зүйлийн 8.1.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.Эсийн донор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.2.1.эсийн донорт насны дээд, доод хязгаар заахгүй, хэрэв бэлгийн эсийн донор бол 18 насанд хүрсэн байна;

8.2.2.хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэн эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр авна;

8.2.3.эсийн донор нь гэр бүлийн гишүүн эсхүл сайн дурын донор байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, П.Наранбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хүүхдээс ясны хэм, хүйн цус, хүйн эд, захын цуснаас бусад эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ,” гэснийг “үндэс, угсаа, хэл,

арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол,” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “үйлчилгээ, түүнтэй холбоотой бусад мэдээ” гэснийг “үйлчилгээний талаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “амьдралын чанарыг хангах тасралтгүй тусламж үйлчилгээг” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар,” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.1.4 дэх заалтын “мөрдөх” гэсний өмнө “дагаж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хонжоо,” гэснийг “олох зорилгоор” гэж өөрчилж, “авах,” гэсний дараа “өгөхийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.6, 9.1.7 дахь заалт тус тус нэмэх:

“9.1.6.эрхтэн, эд, эсээ бусдад шилжүүлэн суулгах явцад өөрийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байх эрхээр хангагдах;

9.1.7.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний явцад технологийн заавар зөрчигдсөний улмаас донорын эрүүл мэндэд хохирол учруулсан нь тогтоогдсон бол эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгасан буруутай этгээд, байгууллагаар хохирлоо нөхөн төлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн гарчгийн “донорт тавигдах шаардлага” гэснийг “донорыг ирүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд амьгүй донороос эрхтэн, эд, эс авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “, дүү” гэсний дараа “төрлийн хүн, садангийн хүн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ж.Чинбүрэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “гадны нөлөөтэй” гэснийг “Гэмт хэргийн улмаас тархины үхэлтэй болох нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын” гэсний дараах “гишүүд” гэснийг “гишүүн, Улсын Ерөнхий прокурор” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6 дахь хэсэг нэмэх:

“10.6.Амьгүй донорт насны хязгаар заахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн гарчгийн “болохоо” гэснийг “болох хүсэлтээ” гэж өөрчилж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн энэ хуулийн 4.1.3-т заасан донор болох хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан гаргаж, донорын цахим үнэмлэх, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулж, донорын үнэмлэх авч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн дугаарыг “11.3” болгон өөрчилж, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Татгалзах хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн дугаарыг “11.2” болгон өөрчилж, мөн хэсгийн “гэрчилгээ” гэснийг “үнэмлэх” гэж өөрчилж, мөн хэсгийн “татгалзах эрхтэй.” гэсний өмнө “хугацаа хамаарахгүй” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “8.1-д заасан шаардлага хангасан амьд донороос эрхтэн, эд, эсийг авна” гэснийг “8.1, 8.2-т заасан шаардлага хангасан байна” гэж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан донороос авах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно” гэснийг “энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авна. Зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эс авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээг үзүүлнэ” гэснийг “үйл ажиллагааг зохион байгуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрлийн дагуу энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагын эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэргэжлийн баг эрхтэн, эд, эс авах эмнэлгийн тусламж үйлчилгээг гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “донороос” гэснийг “донорыг бүртгэх,” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “хадгалах,” гэсний дараа “хамгаалах,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн дугаарыг “12.3” болгож, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Энэ хуулийн 11.1-д заасан амьгүй донороос эрхтэн, эд, эс авахдаа гэр бүлийн 3 хүртэлх гишүүнд урьдчилан танилцуулах бөгөөд энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Эрхтэн, эд, эс шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах” гэснийг “Био банк байгуулах, ашиглах үйл ажиллагаа” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь үндэсний хэмжээнд оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зориулалттай нэгдсэн био банктай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 13.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэх” гэснийг “Био банк байгуулах, ашиглах” гэж, мөн хэсгийн “байгууллагын саналыг үндэслэн” гэсний өмнөх “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.3, 13.4 дэх хэсэг нэмэх:

“13.3.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага нь эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх био банктай байж болно.

13.4.Био банкиг эд, эсийг цуглуулах, шинжлэх, өсгөвөрлөх, боловсруулах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, устгах, шаардлагатай үед эмчилгээ, судалгааны зорилгоор тохирох эд, эсээр реципиент эмнэлэг болон судалгаа, шинжилгээний байгууллагыг хангах зориулалтаар ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шаардлага хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “импортолж болно” гэсний өмнө

“энэ хуулийн 14.3-т заасан журамд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийг хасах:

“15.1.энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага нь донор, реципиентийн эрхтэн, эд, эсийн тохироог үзэх, донороос авсан эрхтэн, эд, эсийг шинжлэх, боловсруулах, шилжүүлэн суулгах мэс засал, эмчилгээг гүйцэтгэх мэргэжлийн багтай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 15.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “13.3-д” гэснийг “12.5-д” гэж, мөн зүйлийн 15.8 дахь хэсгийн “Донор бэлгийн эсийг” гэснийг “Бэлгийн эсийг” гэж, мөн хэсгийн “болох бөгөөд холбогдох журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.” гэснийг “болно.” гэж, мөн зүйлийн 15.9 дэх хэсгийн “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага эрхэлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4-т заасан эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэж болно.” тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.10, 15.11 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“15.10.холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр

дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрөх бөгөөд бусад тохиолдолд тээгч эх ашиглахыг хориглоно.

15.11.Бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэ хуулийн 12.5-д заасан журмыг баримтлах бөгөөд талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн нэг удаагийн амьд төрөлтөд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “байх бөгөөд мэдээллийн аюулгүй байдал технологийн нууцлал, найдвартай байдлыг хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 16.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн” гэснийг “эрүүл мэндийн байгууллага” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шилжүүлэн суулгах” гэсний дараа “тусламж, үйлчилгээний” гэж, мөн заалтын

“баримтлах бодлого,” гэсний дараа “төлөвлөлт, арга хэмжээ,” гэж тус тус нэмж, мөн заалтын “төрөөс” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “ажиллагааг зохион байгуулах,” гэснийг “ажиллагаа,” гэж өөрчилж, мөн зүйлийн 18.1.3, 18.1.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.4 дэх заалт болгон шилжүүлж, мөн заалтын “4.1.8-д заасан” гэсний өмнө “4.1.7,” гэж нэмж, мөн заалтын “механизм” гэснийг “систем” гэж өөрчилж, мөн заалтын “эмнэлгийн мэргэжилтнийг” гэсний өмнөх “эмч,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.5.энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг батлах, хэрэгжилтийг хянах, цуцлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6

Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.1 дэх хэсэг нэмэх:

“19.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан тусгай мэргэжлийн төв байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “12.5-д” гэснийг “12.5, 13.2-т” гэж, мөн зүйлийн 19.1.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “эмчилгээ,” гэснийг “тусламж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 19.1.4, 19.2.3, 19.3.4 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “12.5-д” гэснийг “12.5, 13.2-т” гэж, мөн зүйлийн 19.1.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “эмчилгээ,” гэснийг “тусламж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 19.1.4, 19.2.3, 19.3.4 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалтын “эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхийг дээшлүүлэх,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.2.3 дахь хэсэг нэмэх:

“19.2.3.эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхыг дээшлүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн” гэсний дараах “15.1.4, 15.1.5,” гэснийг, мөн заалтын “15.1.13-т заасан” гэсний өмнөх “15.1.12,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.1 дэх заалтын “донор эмнэлгийн,” гэснийг хасаж, мөн заалтын “ёс зүйн хороодтой” гэсний өмнө “мэргэжил,” гэж нэмж, мөн зүйлийн 19.4.2 дахь заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх” гэснийг “шийдвэрлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн,” гэснийг, мөн хэсгийн “байгууллагын бүтцэд” гэсний өмнөх “байгууллага байх ба тус” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “4.1.6” гэснийг “4.1.7” гэж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “мэдээлнэ.” гэснийг “мэдээлж, улирал тутам тайлагнана.” гэж тус тус өөрчилж, “донорын талаарх мэдээллийг” гэсний өмнөх “амьд, амьгүй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын “хүндрэл, сөрөг нөлөөллөөс” гэснийг “эрсдэл, хүндрэлээс” гэж, мөн зүйлийн 20.2.2 дахь заалтын “энэ хуулийн 20-д” гэснийг “энэ хуулийн 19-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.3.6 дахь заалтын “эрчимт эмчилгээг” гэсний өмнө “амин чухал эрхтний үйл ажиллагааг дэмжин,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.3.8 дахь заалт тус тус нэмэх:

“20.3.8.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд дараах үйл ажиллагааг хориглоно:

21.1.1.донор болон реципиент, тэдний гэр бүлийн гишүүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээдээс аливаа хэлбэрээр урамшуулал, шан харамж авах;

21.1.2.албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох;

21.1.3.Шинжлэх ухааны бус зорилгоор судалгаа, шинжилгээ, туршилт хийх;

21.1.4.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл.Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

22.3.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг 23 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл.Санхүүжилтийн тогтолцоо

23.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, реципиентийн төлөх төлбөр, хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

23.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасны дагуу тогтооно.

23.4.Дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцах бөгөөд худалдан авалт, тасралтгүй бэлэн байдал, хуваарилалт, хяналтын асуудлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулна.

23.5.Хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.11-т заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах албаны дарга Б.Алтантулга хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Л.Энхнасан: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтын “аав, ээжийг” гэснийг “эцэг, эхийг” гэж, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “суулгах” гэснийг “суулгуулах” гэж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “доор дурдсан” гэснийг “дараах” гэж, төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “шаардлагад нийцсэн” гэснийг “шаардлага хангасан” гэж тус тус өөрчлөх;

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтын “эрүүл мэндийн байгууллага” гэсний өмнөх “заасан” гэснийг, төслийн 15 дугаар зүйлийн 15.11 дэх хэсгийн “холбоотой тусламж, үйлчилгээг” гэсний дараах “үйлчилгээг” гэснийг, төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “талаарх” гэснийг, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “ухуулан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Л.Энхнасан: Зарчмын зөрүүтэй 64 дүгээр санал дэмжигдсэнтэй холбогдуулан хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7

Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаар

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Энхнасан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дугаарыг “2” болгож, мөн заалтын 6.19 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын дугаарыг “1” болгож, мөн заалтын 6.1.4 дэх заалтын “, холбогдох баримт бичиг” гэснийг “болон хоорондын байгуулсан гэрээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл тус тус нэмж, төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалтын “Донорын тухай хуулийн 3.1.2-3.1.4-т” гэснийг “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.5-д” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 30 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ирвэл зохих 30 гишүүдээс одоо 17 гишүүн ирсэн байна. Гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 56,7 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааныг нээгдсэнийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн ирсэн байна, Отгоншарын Батнайрамдал гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна, Банзрагчийн Түвшин гишүүн ирсэн байна, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна, Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна, Даваасамбуугийн Ганбаа гишүүн ирсэн байна, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн ирсэн байна, Ганбатын Хосбаяр гишүүн ирсэн байна, Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Гадаадад томилолттой гишүүд Аюушийн Ариунзаяа гишүүн гадаадад томилолттой байна, Буланы Бейсен гишүүн гадаадад томилолттой байна. Мөн чөлөөтэй Жадамбаагийн Баясгалан гишүүн чөлөөтэй байна, орон нутагт Шинэбаярын Бямбасүрэн гишүүн орон нутгийн томилолттой байна, мөн Жанчивын Галбадрах гишүүн орон нутагт томилолттой байна. Өнөөдөр чөлөөтэй гишүүн бол Тогтмолын Мөнхсайхан гишүүн байна, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн чөлөөтэй байна, мөн Дашмягмарын Сарнай гишүүн чөлөөтэй байна, мөн Бадарчийн Хэрлэн гишүүн гадаад томилолттой байгаа юм байна. Ингээд гишүүдийн ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр 4 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт, Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тухай хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Уянга, Рэгдэл, Хосбаяр нараас 2025 оны 7 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. 2 дугаар асуудал Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. 3 дугаарт, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Ганмаа нарын 37 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн байна. 4 дүгээр асуудал бусад.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Бусад асуудал нь Байнгын хорооны даргыг сонгох. Тэгэхлээр горимын санал гаргах ёстой, би өөрөө бараг гаргачихъя. Тийм. Эхлээд нөгөө 3 дугаар асуудал дээр санал байгаа.

Тэгэхлээр Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудал дээр нам, эвслийн бүлгээс хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд оруулах нэрсийг ирүүлээгүй байгаа учраас энэ асуудлыг хойшлуулж байна. Энэ асуудлыг хойшлуулах санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье. Бумба-Очир гишүүн, Ганзориг гишүүн, Ганмаа гишүүн, Хосбаяр гишүүн, Чинбүрэн гишүүн, Энхцэцэг гишүүн ороогүй байна шүү. Ирцдээ гишүүд орсон байна. Энэ асуудлыг хойшлуулах санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 76,5 хувиар санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын 4-д тусгагдсан бусад асуудал буюу Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэх асуудлын эхэнд оруулах санал гаргаж байна. Энэ асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Ганбаатар гишүүн, Энхтуяа гишүүн бас ороорой. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцсоны 14 нь зөвшөөрсөн байна, 82,4 хувиар санал дэмжигдлээ. Тэгэхлээр 1 дүгээр асуудлаа хэлэлцье.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцье. Дэгийн тухай хуулийн 23.1 Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ. Байнгын хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулахыг Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр танилцуулна.

П.Наранбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. ХҮН намын зөвлөл дотроо албан ёсоор ярилцаад, Улсын Их Хурлын даргатай бас зөвшилцсөний үндсэн дээр энэхүү Байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг танилцуулъя. Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс нэр дэвшигчийн төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийн нэрийг дэвшүүлж байна.

Пүрэвжавын Ганзориг нь 1984 онд төрсөн, эхнэр, хүүхдийн хамт амьдардаг. 1991-ээс 2001 онд Хөвсгөл аймгийн 10 жилийн дунд сургууль, 2001-ээс 2005 онд МУИС-ийн Математик, компьютерын сургуулийг тус тус төгссөн, математикч мэргэжилтэй. 2005-аас 2008 онд тийм математикч мэргэжилтэй, 2005-аас 2008 онд Номин даатгал хувьцаат хариуцлагатай компанид, хязгаарлагдмал хариуцлагатай компанид эрсдэлийн шинжээч, актуарч, 2008-аас 2011 онд Номин даатгал компанид гүйцэтгэх захирал, 2010-аас 2013 онд Монголын даатгалын холбооны ерөнхийлөгч, 2018 оноос Үндэсний стратегийн хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн, 2016-аас 2020 онд Их Эрин Холдинг ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн дарга, 2020-оос 24 онд НИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч, 2020-оос 24 онд Хан-Уул дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, бүлгийн дарга, 2015 оноос ХҮН намын Удирдах зөвлөлийн гишүүн, 2016-аас 2020 онд ХҮН намын Хяналтын ерөнхий хорооны дарга, 2021-ээс 2026 онд ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2024 оноос Монгол Улсын Их

Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлийн даргаар тус тус ажиллаж байна. Танилцуулж дууслаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Байнгын хорооны даргад, Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж дууслаа. Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу.

С.Эрдэнэбат: Ганзориг гишүүнийг дэмжиж байгаагаа түрүүлээд хэлмээр байна. Нийгмийн бодлогын байнгын хороо маань эрхлэх асуудал нэлээн өргөн, улсын төсөв ч гэсэн юутай холбоотойгоор авхуулаад энэ цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудлууд, боловсрол, эрүүл мэнд гээд энэ тал дээр таны хувьд хамгийн түрүүнд юу хийе гэж бодож байгаа вэ гэдгийг тодруулж асуумаар байна. Өнгөрсөн хугацаанд энэ цалин хөлсний асуудал энэ тэрийг эргээд харахад одоо хүртэл дуусаагүй шинэ, хуучин сайдууд маань наана цаана гэдэг зүйл яриад байгаа. Гэхдээ энэ дээр Байнгын хороон дээр хариуцлагатайгаар хэлэхэд маш тодорхой асуудлуудыг бид хэлчихсэн, маш тодорхой тоо юмнууд яригдсан. Тийм учраас цаашдаа асуудал болоод дууссаны дараа ч гэдэг юм уу, тэр, энэний буруу гэхээсээ илүү энэ бол багийн манай Байнгын хорооноос орж ирсэн саналуудыг нь бүгдийг нь дэмжсэн. Харамсалтай нь Төсвийн байнгын хороон дээр очиж будаа болгосон, танигдахааргүй болгосон, төсвийг дутаж байгааг одоо энд сууж байгаа Наранбаяр сайд байна, Чинбүрэн сайд 2 бол хоёулаа л яг шаардлагатай бодит төсвүүдийг оруулж ирж байсан. Бид байгаа боломжид нь тааруулаад л шийдэж байсан гэдгийг онцолж хэлмээр байна.

Тийм учраас Ганзориг гишүүний хувьд эдийн засагч, математикч чиглэлийн хүн учраас, даатгалын чиглэлийн мэргэжлийн хүн учраас энэ Нийгмийн бодлогын байнгын хооронд нэмэр болох болов уу гэж би бодож байна. Өөрөө асуудал ихтэй, нийгмийн хамгийн түрүүний хүлээлттэй олон асуудлууд байж байгаа. Тийм учраас энэ тал дээр танаас хамгийн түрүүнд юуг бодож нэр дэвшиж орж ирсэн, ХҮН намаас бас Ганзориг гишүүнийг дэвшүүлэхдээ ямар чиглэл, юуг өгсөн бэ гэдгийг тодруулж асуумаар байна.

Л.Энхнасан: Ганзориг гишүүний микрофоныг өгье.

П.Ганзориг: Байнгын хорооныхоо нийт гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Мэдээж энэ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо бол 4 салбарын асуудал хариуцсан том Байнгын хороо. Байнгын хорооны үндсэн чиг үүрэг бол бид бүгд мэдэж байгаа. Энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эндээ энэ салбарын бодлогуудыг дэмжих, салбарын бодлогод хэрэгцээ шаардлагатай төсөв мөнгөний асуудлыг шийдвэрлэх, салбар хоорондын уялдааг хангах, шаардлагатай ажлын хэсэг болоод чиг үүрэг бүхий ажлын хэсгүүд гаргаж ажиллах гээд энэ чухал асуудлууд хариуцаж байгаа юм. Тэгээд энэ 4 жилийн маань парламентын бүрэн эрхийн хугацааны 2 жил буюу яг энэ бараг дундаа орж байна. Тэгэхээр үлдсэн бид хугацаандаа бол Байнгын хороо төдийгүй Их Хурлын түвшинд, Засгийн газар /ЗГ/-ын түвшинд гээд маш их санаачилгатай, хурдтай ажиллахгүй бол энэ салбарын асуудлууд хуримтлагдсан байж байгаа.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд би Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд ажиллаж байхдаа энэ салбаруудын эрүүл мэндийн салбар,

боловсролын салбар гээд, нийгмийн хамгааллын салбарын ер нь суурь асуудлуудыг шийдэхэд энэ төсвийн тогтолцооны асуудлыг сууриар нь нэг харж шинжилж, одоо эрүүл мэнд, нийгмийн даатгал гэдэг чинь ерөөсөө тогтолцоо сууриар нь харж шинэчлэхгүй л бол энэ явахааргүй болчихоод байгаа шүү дээ. Тэгээд ийм бодлогын асуудлууд дээр, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болох асуудлууд дээр энэ Байнгын хороонд ажиллаж байгаа туршлагатай, мэргэжлийн гишүүдтэйгээ хамтарч энэ асуудлуудыг яаралтай оруулах тал дээр анхаарч ажиллана л гэсэн ийм бодлого чиглэлтэй байж байгаа.

Ер нь өнгөрсөн жил ялангуяа энэ төсөв батлах үед боловсролын салбар болоод эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг нэмэхэд бол төсөв мөнгөнийх нь бололцооных нь хүрээнд төсөв дээр шаардлагагүй байгаа үрэлгэн зардлуудыг хасаж, энэ суурь хүний хөгжлийн асуудлууд руу чиглэсэн зардлуудаа нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх дээр саналууд гаргаж би ажиллаж байсан. Боловсролын салбарт гэдэгт бид төсвийн хэмжээнд байж болох хэмжээндээ жил бүтэн жилийн хугацаанд 630 орчим тэрбум төгрөгийг нэг жилд төсвийг нэмэгдүүлсэн. Энэ бол өмнөх парламент болоод, түүхэнд нэг жилийн дотор ингэж өндрөөр нэмэгдүүлж байсан зүйл байхгүй. Эрүүл мэндийн салбарын ч гэсэн ажилтнуудын бид цалинг тодорхой боломжоор нь нэмсэн. Тэгэхээр иймэрхүү байдлаар энэ төсөв талдаа. Ер нь энэ бодлогыг хэрэгжүүлдэг гол хэрэгсэл нь төсөв. Тэгэхээр хууль, эрх зүйн орчин гаргаж ажиллахаас гадна энэ төсвийнх нь боломжийнх нь хүрээнд энэ салбарын асуудлуудыг төсвийн бодлогоор дэмжих чиглэл дээр бол илүү түлхүү ажиллана л гэсэн саналтай байгаа. Тэгээд энд дандаа салбарын мэргэжлийн, туршлагатай хүмүүс байгаа учраас та бүхэнтэйгээ хамтраад энэ богино хугацаанд үр дүн гаргаж ажиллана гэсэн ийм л бодлого барьж ажиллана. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Наранбаяр гишүүн асуултаа, хариулна уу.

П.Наранбаяр: Энэ ХҮН намын зүгээс Ганзориг гишүүнийг зөвлөлийн даргын хувьд, мөн Байнгын хорооны даргаар ингэж танилцуулагдаж байгаа ийм үед ямар захиас, ямар бодлогын захиалга өгсөн бэ гэсэн асуулт байлаа. Тэгэхээр энэ дээр бид Үйлдвэрчний эвлэлийг нийгмийн хамгийн чухал ийм түншлэгч байгууллага гэж хардаг. Нийгмийн түншлэлийн, ялангуяа хамтын хэлэлцээ гэдэг үндэсний хэмжээний энэ бодлого дээр салбарын бодлогыг, ялангуяа цалингийн бодлогыг хэрэгжүүлэхэд хамгийн чухал түншлэгч гэж хардаг. Энэ утгаараа Ганзориг гишүүнийг илүү ойлголт сайтай ийм гэж харж байгаа. Энэ зүгээс бид энэ цалингийн бүтцийн бодлого дээр үйлдвэрчний эвлэлтэй ярилцсан ийм зүйлүүд бий. Тэгэхээрээ цалингийн бүтцийг үндсэн цалин нь амьдралын баталгаа болж байдаг, үндсэн цалинг нь тогтвортой нэмэгдүүлж, өнөөдөр зөвхөн багш, эмч гэхгүй, нийт төрийн албан хаагчийн амьдралын баталгаа болох ийм хэмжээнд нь аваачиж, цаашдаа тэтгэвэрт гарахдаа ер нь боломжийн хэмжээний тэтгэвэр авч, тэтгэвэрт гарсан эхний өдрөөсөө Монгол хүн ядууралд ордоггүй байх ийм бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэж үздэг, үндсэн цалингаас тооцдог шүү дээ.

Зээлжих ийм чадварыг нь бас сайжруулах ёстой гэж хардаг. Ипотекийн зээлд хамрах энэ боломжуудыг хардаг. Тэгэхээр аливаа нэмэгдлээр нүд хуурч ирэхээ больё, аливаа нэмэгдлээр энэ цалинг нь аргалах гэж явахаа больё. Энэ чинь үндсэн цалингаар нь л өнөөдрийн албан хаагчдынхаа тогтвортой амьдралын баталгааг хангадаг, энэ цаашаагаа мэдээж сайн гүйцэтгэлтэй ажилтныг урамшуулдаг энэ

тогтолцоо руу орох нь зүйтэй. Гэхдээ энэ харьцаа бол эрүүл 70, 30 гэсэн ийм харьцаа руу явах ёстой. Энийг зөвхөн бид ярьж байгаа юм биш, олон улсын хөдөлмөрийн байгууллага ч хэлж байгаа. Дэлхийн банкнаас ч гэсэн Монголд төрийн албан хаагчдын цалингийн шинэчлэл дээр энэ асуудлыг ярих ёстой. Үүнийгээ ийм нүсэр бус, түсэр бүтэц рүү оруул гэсэн ийм байр суурийг барьдгийг бид бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм.

Тэгэхээр цаашдаа ингээд явбал бид өнөөдөр энэ төрийн албан хаагчдыг илүү чадварлаг болгох, илүү шигшиж авах ийм боломжийг бий болно гэж ингэж харж байгаа. Энэ дээр ч гэсэн өнөөдөр энэ Байнгын хороон дээр ажиллаж байгаа нийт гишүүддээ хандаж уриалахад энэ тал дээр хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Найдалаа гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүн үгээ хэлнэ үү.

С.Зулпхар: Байнгын хорооны хуралдаан даргалагч, Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Ганзориг гишүүнийг манай Байнгын хорооны даргаар нэр дэвшүүлж байна, бид дэмжиж байна. Бас зохих түвшний улс төрийн ажлын бодлого тодорхойлж, бодлогыг орон нутгийн түвшинд тодорхойлж хэрэгжүүлэх ийм туршлагатай, цаашлаад ХҮН намын хувьд бодлогыг нь өөрөө тодорхойлох, бодлогыг нь тодорхой салбаруудаар хэрэгжүүлэх чиглэлээр маш тодорхой саналууд гаргаж ажилладаг ийм гишүүн учраас манай Байнгын хороог даргалаад явах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Би мэдээж хэрэг өнгөрсөн хугацаанд Байнгын хорооны ажилтай хийсэн ажилтай холбогдуулаад тодорхой санал хэлье гэж бодож байна. 1 дүгээрт, 2025 оны 11 сарын 25-ны өдөр манай Байнгын хорооноос 2026 оныг Боловсролын хөгжлийг дэмжих жил болгож байгаатай холбогдуулаад хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг баталж гаргасан байгаа. Наранбаяр сайд бас таны дэргэд сууж байна. Энэ ажлыг тодорхой түвшинд гардаж, эхнээс нь хэрэгжүүлээд явж байсан ийм сайд. Тэгэхлээр энэ жишээ нь тогтоолын хэрэгжилтийг бид 2026 оны хаврын чуулганаар бол үр дүнг нь эхнээс нь бол сонсож, хэлэлцэж, дахиад энэнтэй холбоотой бид төсвийн ирэх жилийн тухайд ямаршуу чиглэл гаргах вэ, ямаршуу дэмжлэг үзүүлэх вэ гэдгээ тодорхойлно гэсэн байгаа юм. Тэгэхлээр энийг бид, үүнийг би 5 сардаа багтаагаад хэлэлцэх чиглэл та аваач гэсэн ийм санал байна зайлшгүй.

Яагаад гэвэл энэ дотор маш чухал бэлтгэл ажлууд хангагдсан байх ёстой. Хиймэл оюун ухааныг бид сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх, багш нар хиймэл оюун ухаанаар дамжуулж өөрсдийнхөө хичээлийнхээ хөтөлбөрийг бэлэн болгох, сургалтад ашиглах гээд том ажлууд хийгдээд явж байгаа. Энэний үр дүн бид эхнээс нь ярих ёстой юм байгаа юм. Энийг ярьж байж бид 2027 оны төсөв хэлэлцэхдээ энэ чиглэлээр бид ямар арга хэмжээ авах вэ гэдгээ тодорхойлж явах ёстой юм.

Англи хэлтэй холбоотой, гадаад хэлний сургалттай холбоотой бэлтгэл хангаж байгаа. Энэ чиглэлээр хийгдэж байгаа ажил бий. Багш нарын мэргэжил дээшлүүлэх ажил бий. Үүнийг бид ярих ёстой. Их, дээд сургуулиуд дээр маш тухайлсан чиглэлүүд гаргасан. Зарим хичээлийн хөтөлбөрүүдийг бид хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулсан байдлаар эргэж харах, энэний үр дүнг ярих ёстой. Энийг бол бид ярих ёстой учраас 5 сарын та чиглэлдээ аваач гэсэн ийм санал байна.

2 дахь зүйл манай Байнгын хорооны бүрэлдэхүүнд Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо бий. Дэд хорооны гишүүд маань бас энд сууж байна. Рэгдэл гишүүн энд сууж байна, Бум-Очир гишүүн, Хосбаяр гишүүн. Ингээд гишүүд сая намрын чуулганы завсарлагаагаар шинжлэх ухааны байгууллагуудаар явж ажилласан. Шинжлэх ухааны байгууллагуудаар явж ажиллаад бид 11 санал зөвлөмж бүхий ийм тайлан бэлэн болгосон байгаа. Тайланг төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлсэн. Манай Байнгын хороонд бас хүргүүлсэн байгаа. Үүнтэй уялдуулаад бид энэ шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх тодорхой тогтоолын төсөл гаргах ёстой. Тэгж байж энэ дээр бол үр дүн гарна гэж үзэж байгаа учраас энэ дээр та бас анхаарч өгөөрэй. Бид тогтоолын төслийг төрийн захиргааных нь төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтарч энийг оруулж ирнэ.

Цаашлаад сая энэ тогтоолын төсөлтэй уялдсан байдлаар Шинжлэх ухаан, технологийн хууль, бусад холбогдох хуулиуд дээр ахиад нэмэлт, өөрчлөлт оруулах ийм шаардлага гаргах юм шиг байна. Энэ талаар бол бид хууль санаачлах ийм чиглэл яригдсан байгаа, манай дэд хорооны гишүүд маань. Үүнийг танд тухайлан жич танилцуулна гэсэн ийм бодолтой байна. Ингээд таны ажилд амжилт хүсье. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга болон одоо Эрчим хүчний сайдаар ажиллаж байгаа Найдалаа гишүүн үгээ хэлнэ үү.

Б.Найдалаа: Баярлалаа. Юуны өмнө Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны шинээр байгуулагдсан, нэгтгэж байгуулсан томоохон Байнгын хороо. Хүний гэсэн нэртэй хүний хөгжлийн төлөө энэ Байнгын хорооны анхны даргаар ажиллах боломж олгосон, дэмжсэн Байнгын хорооны гишүүддээ, мөн хамтран ажиллаж, дэмжиж байсан бат бэх ар тал болж ирсэн ажлын албаны хамт олондоо талархлаа илэрхийлье.

Өнөөдөр Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа мөн Пүрэвжавын Ганзориг гишүүндээ баяр хүргэж, амжилт хүсье. Тэгээд маш товчхон гишүүддээ хандаад, мөн шинээр даргад нэр дэвшиж байгаа Ганзориг гишүүндээ хандаад нэг товчхон санаа хэлье. Манай Байнгын хороо бид гишүүдтэйгээ ярилцаад, хэдэн зарчим барьж ирсэн. Хүний хөгжил болохоор боловсрол байна уу, эрүүл мэнд байна уу, нийгмийн хамгаалал, хөдөлмөр байна уу, соёл байна уу эцсийн дүндээ энэ 4 салбар бол хүний төлөө салбар байгаа. Тэгээд хүний хөгжил гэж нийлүүлсэн нь уг нь маш зөв концепт зарчим байсан юм. Салбар хоорондын уялдааг хангахад энэ Байнгын хорооны үүрэг маш чухал байсан. Зөвхөн нэг салбараа бариад, салбарын төлөө биш, хүний төлөө явах тэр өөрчлөлт, зарчмын өөрчлөлтийг хийхийн төлөө бид ярьж тохирсон. Тэрний төлөө ажиллаж ирсэн. Энийг Ганзориг гишүүн үргэлжлүүлээд явах байх.

Гишүүд маань Улсын Их Хурлын гишүүд бол улс төрчид. Өөр өөрийн сэдэвтэй, өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй, тэрнийхээ төлөө зүтгэдэг, явдаг, тэмцдэг хүмүүс. Асар их асуудал байхад бид жижиг асуудлаар хоорондоо маргалдаж, мэтгэж цагаа барж яах юм бэ, хүчээ барж яах юм бэ. Том асуудлуудаа хамтдаа тодорхойлоод, тэгээд сэдвээ хувааж аваад, зохих газар нь хамтраад, дэмжээд аль болох олон асуудлыг шийдэх, олон хууль, тогтоолыг батлахын төлөө ажиллая гэж бид ярьж байсан. Тэгэхээр одоо ч гэсэн яг Ганзориг дарга маань даргаар сонгогдвол энэ чиглэлээр яг иймэрхүү зарчим бариад ажиллаасай гэж хүсэж байгаа. Манай

гишүүд бол маш эвлэг, том, том асуудлыг бариад явдаг ийм юу гэдэг юм туршлагатай, үнэхээр дэм болж байсан гишүүд байгаа.

Одоо явж байгаа хэдэн асуудал байгаа. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, би өөрөө ахлаад явж байсан. Гэхдээ одоо энэ ажилдаа оролцсоор байх болно, хуулийг санаачилна гэж бодож байгаа. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ялангуяа энэ Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт 30-хан хувь байсан. Түүн дээр бид ажлын хэсэг, Их Хурлын Байнгын хороодоос хамгийн анх бид шууд томилж байсан. Одоо тэр Ариунзаяа гишүүний ахалсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ бол маш чухал. Хэрэггүй шийдвэрийг хэрэггүй бол, хэрэгжихгүй юм бол, төсвийг нь тавьж өгөхгүй юм бол батлахаа больё гээд. Шийдвэрийн чанарыг сайжруулж байж үр дүн гарах юм байна лээ л дээ. Тэгээд энэ дээр манай Байнгын хорооны шинэ дарга болон гишүүд маань үргэлжлүүлээд ажиллаасай гэж бодож байгаа.

Тэгээд бас нэг чухал зүйл бол яамдтайгаа хамтран ажиллах. Гишүүд хоорондоо ярьдаг байсан. Байнгын хорооны эцсийн зорилго бол яамдаа дэмжих. Яамандаа ажиллах эрх зүйн орчноор нь бүрдүүлэх бодлогын хувьд дэмжих. Тийм болохоор зарим тохиолдолд яамд маань ажил ихтэй, асуудал ихтэй, тулгамдсан асуудалдаа тулгуулж явдаг учраас асуудлаа орхих тохиолдол байдаг. Энэ дээр нь гишүүд, энэ олон гишүүдийн мэдрэмж, мэдлэг маш их орон зайг нь нөхнө гэж боддог. Тийм болохоор яамд дээр жишээлбэл Эрүүл мэндийн яам /ЭМЯ/ дээр амиа хорлолтын тухай асуудлыг бид хэлэлцэж байсан. Та бүхэн санаж байгаа бол, энийг бол ЭМЯ-ан дээр хийж байгаа ажил. Гэхдээ бид хүч өгөхийн тулд, орон зайг нь нөхөхийн тулд тусгайлан ажлын хэсэг байгуулаад ажиллаж байсан. Гэх мэтчилэн ингээд яамдын маань, ЗГ-ын хийж чадахгүй байгаа ажил дээр нөхөн ажиллаасай гэж хүсэж байгаа.

Тэгээд Байнгын хороо бол парламентын Монгол Улсын Их Хурлын хамгийн хүчтэй цэг нь түлхүүр институт нь. Тэгээд энд сайн байгаад, сайн ажиллавал Засаг ер нь төрийн бодлого сайн явах юм байна лээ. Ийм учраас та бүхэндээ, Байнгын хорооны гишүүддээ амжилт хүсье. Онцгойлон даргаар сонгогдох гэж байгаа Пүрэвжавын Ганзориг гишүүнд амжилт хүсье. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшигч Пүрэвжавын Ганзоригийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Чинбүрэн гишүүн ороогүй байна, орчихлоо. Санал хураалт. 17 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 94,1 хувиар дэмжигдлээ. Ганзориг гишүүндээ баяр хүргэе. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвсүрэнгийн Наранбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

14.57 цаг

Хоёр.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Улсын Их Хурлын гишүүн Уянга, Рэгдэл, Хосбаяр нараас 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Шинжлэх

ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Сархадын Зулпхар танилцуулна. Гишүүний микрофоныг өгнө үү.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нараас 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Монгол УИХ-д өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж туссан, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч С.Зулпхар.

Л.Энхнасан: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.1.3-д заасны дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Зулпхар гишүүн танилцуулна.

15.00 цаг

Гурав.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Ариунзаяа, Алдаржавхлан, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Байнгын хорооны хуралд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Эрдэнэбаяр ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/, Наранпүрэв ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Жаргалсайхан ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Батчулуун Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх, Алтантулга Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга, Одхүү РМС үр шилжүүлэн суулгах эмнэлгийн эмч, Баян-Өндөр ирээгүй байна.

Байнгын хорооны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа. Эрүүл мэндийн сайд хаачихсан юм бэ? Харин тийм, сайдыг дуудаарай. Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Микрофоныг өгнө үү.

Б.Баярбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 252 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Баясгалан, Энхнасан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат нарын гишүүд ажиллалаа. Мөн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтнүүд болон төрийн болон төрийн бус байгууллагуудын холбогдох албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бүрэлдэхүүнийг байгуулан ажиллав.

Ажлын хэсэг болон ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бүрэлдэхүүн хэсэг өнгөрсөн хугацаанд нийт 17 удаа хуралдлаа. Ажлын хэсэг хуулийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, ЭМЯ, Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналуудыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаарт багтаан төслийн үзэл баримтлалын хүрээнд зүйл, хэсэг, заалт нэг бүрээр ярилцаж, дараах агуулга бүхий саналуудыг бэлтгэсэн болно.

Үүнд, 1.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомжийн нэр томъёоны тодорхойлолтуудын үг хэллэгийг иргэд, олон нийт ойлгоход хялбар, энгийн, салаа утгагүй байдлаар илүү нарийвчлан томъёолж, хуульд хэрэглэгдэж буй сорьц, хүйн эд, үндэсний хүлээх жагсаалт зэрэг зарим нэр томъёоны тайлбарыг тодорхойлж нэмж тусгалаа.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг тусгалаа.

3.Эд, эсийн шилжүүлэн суулгах эмчилгээг илүү эрчимтэй хөгжүүлэх зорилгоор эсийн ангиллыг тусад нь зүйл болгон дэлгэрүүлж, олон улсад хэрэглэгдэж буй эмчилгээний шинэ технологи болох эд, эсийг хадгалах тусгай зориулалтын сан буюу био банкны зохицуулалтыг шинээр тусгалаа.

4.Амьд донорт тавигдах шаардлага, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх асуудлыг олон улсын жишиг зарчимд нийцүүлэн томъёолсон.

5.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ болон Станбулын тунхаглалын Хүн болон хүний эрхтний наймааны эсрэг тунхаглал зарчмуудыг хуулийн төсөлд мөрдлөг болгож тусгалаа.

6.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааг илүү оновчтой болгох хүрээнд шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллагуудын чиг үүрэг, хоорондын уялдааг нарийвчлан тодорхойллоо. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг та, зарчмын саналуудыг та бүхэнд хүргүүлсэн тул хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос, ажлын хэсгээс асуулт асууж болно. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Тийм. Зүйл зүйлээр шүү дээ, 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй гишүүд. Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Чинбүрэн гишүүн асуултаа асууна уу.

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгийнхэн та бүхэнд талархалтай хандаж байна. Бүтэн жилийн дараа, бүтэн жил ажиллаж энэ хуулийн төслийг сайжруулах чиглэлд нэлээдгүй хүч хөдөлмөр гаргасан та бүхэнд дахин баярласнаа хэлчихье. Энэ дээр 1 дүгээр зүйл дээр хүний гэдэг юу орж ирж байна тийм ээ. Төсөл бол Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль байсан. Хуулийн төслийн нэрийг Эрхтэн, эд, эс гэсний өмнө хүний гэж нэмэх гэж байгаа юм. Тэгэхлээр зүгээр энэ дээр бид жоохон ирээдүй, алсыг харсан байх хэрэгтэй. Ер нь технологи, анагаах ухааны шинжлэх ухаан бол их асар хурдтай хөгжиж байна. Тэр дотроо бүр тэр битгий хэл амьтны эрхтнийг хүнд суулгах боломжтой болох гэж байгаа байхгүй юу. Жишээлбэл хүнд хамгийн ойрхон байдаг амьтан бол гахай байдаг. Гахай хүнтэй их ойролцоо. Дархлаа, дарангуйлах систем илүү сайн хөгжиж байна, технологи илүү сайжирсан. Тийм учраас гахайд ургуулаад хүртэл эрхтнийг хүнд суулгахыг байг гэхгүй.

Тийм учраас Баярбаатар даргаас би асуух гэж байгаа зүйл хүний гэдэг үг маань энэ ерөнхий хууль маань өөрөө эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах байсныг зөвхөн хүний болгочхож байгаа байхгүй юу. Тэгэхлээр хүнээс ч авна, хүнээс ч суулгана, хүнд суулгана гэсэн санаа орчхож байна. Тийм учраас энэ дээр та хэд бодолцсон уу, энэ тухай ярилцсан уу энэ дээр санаагаа хэлээч? Би бол хүний гэдгээ оруулахгүйгээр ерөөсөө л эрхтэн, эд, эс гэдгээр явчхаасай л гэж хүсэж байгаа.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн ахлагч хариулья.

Б.Баярбаатар: Ажлын хэсгийн хүрээнд өргөн хэлэлцүүлгийг энэ яг хүний гэдэг үгтэй холбож хийсэн. 1 дүгээр гол зорилго бид энэ 96 оноос хойш 30 дахь жилдээ энэ эрхтэн шилжүүлэх мэс засал хийгдээд явж байгаа. Хууль, эрх зүйн анхдагч хуулийн төсөл орж ирсэн. Ямар ч байсан нэг эрх зүйн орчинтой болох зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа. Энэ хүрээндээ бид энэ хүний гэдэг хуулийн нэр томъёонд хүний эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай гэдэг байдлаар эхний байдалд нэг томъёолж оруулж ирэх нь зөв юм болов уу. Ганцхан эрхтний асуудал биш, эд, эс гэдэг зүйл бас орж ирж байгаа манай хуулийн зохицуулалтаар.

Тэгэхээр Чинбүрэн хууль санаачлагчийн ярьж байгаатай би зарим нэг зүйлээрээ санал нэг байна. Цаашлаад энэ 3 асуудлын хүрээнд зохицуулж байгаа

учраас тодорхой хязгаар байх ёстой юм байна гэж үзэж, дээр нь энэ анагаахын чиглэлийн судалгаа хийдэг эрдэмтэн судлаачид, докторуудтай би нэлээн уулзаж ярилцаж байгаад энэ хуулийн нэр томъёо дээр хүний гэдгийг оруулаад, ажлын хэсэг ингээд дэмжиж санал хураасан. Мэдээж хөгжлийнхөө хэрээр манай хуулийн төсөл нэлээн өөдрөг дэвшилтэт ийм хуулийн төсөл байгаа. Хөгжлийнхөө хэрээр тодорхой асуудлууд нээгдэх боломж нь байгаа. Эрхтэн гэдгээсээ илүүтэйгээр эд, эсийн асуудлыг тодорхой түвшинд ярьж энэ асуудлыг оруулсан. Тэгээд Байнгын хороо өөрсдөө шийдвэрээ гаргаж болно. Тийм. Ажлын хэсэг бол ажлын хэсгийн түвшиндээ шийдээд оруулж ирсэн зүйл байж байгаа. Тийм.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хариулах уу? Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Батчулуун Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх. Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь болбол анх манай хуулийн төсөл орж ирэхдээ Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хууль гэдэг нэртэйгээр орж ирсэн. Тэгээд яах вэ манай ажлын хэсгийн ахлагчийн саналаар ер нь бол хүний гэдэг асуудлыг нэмж оруулъя гэсэн санал орж ирсэн. Гэхдээ бид бас энэ дээр нэлээн ярилцсан юм. Учир нь бол одоогоор яг манай Монгол Улсад бол яг амьд амьтнаас хүнд эрхтэн шилжүүлэн суулгах асуудал бол яг бодитойгоор бэлэн болоход тодорхой хугацаа шаардагдах учраас ямар ч байсан хүний гэдэг асуудлаараа эхэлж яваад, мэдээж тодорхой хугацааны дараа энэ бол ирээдүйг харсан асуудал орж ирэх нь ойлгомжтой. Тэр үед нь бол бүх юм нээлттэй байя гэдэг асуудлыг ярилцсан юм.

Л.Энхнасан: Чинбүрэн гишүүн тодруулга.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр ер нь бид нэг ийм технологи руу илүү урагшаа харсан, дараа нь ойр ойрхон л Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулиа өөрчлөөд байхгүйн тулд би Байнгын хорооны гишүүддээ хүний гэдэг үгийг авчихъя гэж бодож байна. Заавал энэ байсан байгаагүй энэ угаасаа л Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль гээд л орчиход энэ тэр ойлгомжтой байгаа л гэж бодож байна.

Нөгөө талаасаа бид ингээд жил төсөл өргөн барьчаад байж байхад дэлхийн улс орнууд гэхэд чинь л эсийн тухай, эсийн технологийн дэвшил хөгжил бүр хуулиуд нь батлагдаад бид хойно нь хоцроод яваад байгаа байхгүй юу. Тийм учраас бид их шуурхай, бүтээлч байх үүднээсээ, дээрээс нь ойр ойрхон солиод байхгүйн тулд, дээрээс нь заавал хүний гэснээрээ энэ хуулийн утга санаа, агуулга нэг их алдагдчихгүй юм чинь ерөөсөө л энэ эртхэн, эд, эс шилжүүлэн суулгах гээд анхны төслийн хуваариараа явчхаасай гэж хүсэж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Санал хураалтаараа шийдэх байх. Алтаншагай гишүүн асуултаа асууна уу.

Н.Алтаншагай: Баярлалаа. Тодруулах хэдэн зүйл байгаа юм. Энэ хууль маань нийгэмд шинээр үүсэж байгаа харилцааг зохицуулах ач холбогдолтой хууль гэж бодож байна. Энэ маань өмнө нь бол Донорын тухай хууль гэж байсан байх. Яг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах гэсэн энэ чиглэлээр байгаагүй байх, өмнө нь яаж зохицуулагдаж байсан юм бол гэж байгаа юм 1 дүгээрт?

2 дугаарт Монголд яг хэдэн энэ төрлийн хэдэн төрлийн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тэр хагалгаа, энэ процессыг Монгол Улсын хэмжээнд хийж байгаа вэ? Эсийн түвшнийг нь энэ дотроо оруулж байгаа юу? Нөгөө үр шилжүүлэн суулгах тээгч эх маань энэ дотор орох юм уу, тусдаа байх юм уу гэж энэ зохицуулалтыг асууж байна?

Амьд донорын эрхтэн шилжүүлэхийг энэ хэмжээ заах уу? Сүүлийн үед энэ Монголчууд чинь элэг их шилжүүлэн суулгаж байгаа, амьд донороос нь авч өвчтөнд шилжүүлэн суулгаж байгаа энэ дээр нь яг элэгний тэр хэмжээ, хувийг зааж өгч байгаа юу? Амьд донорт нь хэдэн хувийг нь авбал боломжтой, хэдэн хувь нь үлдэх ёстой гэсэн энэ зохицуулалтуудаа хууль дээр яг орж өгөх үү? Тэгээд тодруулъя.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Сүүлээс нь эхлээд хариулъя. Ер нь бол бид манай элэг шилжүүлэн суулгах эмчилгээний удирдамж гэж заавар гэж байдаг. Энд бол амьд донороос элэг шилжүүлэн суулгах үйлчилгээний үед бол хүндээ 35 хувийг нь зайлшгүй үлдээх ёстой байдаг. Тэгэхгүй бол нөгөө үлдэж байгаа элэг маань бол нөгөө амьд донорынхоо амьдрал ахуйг амьдралыг бол дэмжиж чадахгүй болдог учраас 65 хувиас дээш хэсгийг нь бол элэг шилжүүлэн суулгах мэс заслаар авдаггүй ийм тал байгаа. Ер нь өнөөдрийн байдлаар манай Монгол Улсад хэчнээн элэг, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн бэ гэхлээр Улсын 1 дүгээр төв эмнэлэг дээр бөөр шилжүүлэн суулгах эмчилгээг 455 хүнд хийсэн байна. Элэг шилжүүлэн суулгах эмчилгээг 364 хүнд хийсэн байна. Энэ дотроос 2 хүнд цусны бүлэг тохироогүй хүмүүст элэг шилжүүлэн суулгасан ийм эмчилгээ хийсэн. Ясны чөмөг үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг яг өнөөдрийн байдлаар 42 хүнд хийсэн. Эдгээрийн маань үр дүн бол 95-аас дээш хувьтай ийм явж байгаа.

Хавдар судлалын үндэсний төв /ХСҮТ/ дээр өнөөдөр бол 244 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай хийсэн. Ингээд хамтарсан багууд ажиллаж байгаа. Жишээ нь бол Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/, 2 дугаар эмнэлэг, Цэргийн төв эмнэлгүүд дээр, Улсын 1 дүгээр төв эмнэлгийн баг хамтарч ЭХЭМҮТ дээр 6 хүүхдэд элэг, 4 хүүхдэд бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ, Улсын 2 дугаар төв эмнэлэг дээр 5 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээ, Цэргийн төв эмнэлэг дээр 4 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн байна.

Энд бид хуулийнхаа төсөлд үр шилжүүлэн суулгах эмчилгээний асуудлыг бас оруулж өгч байгаа. Үүдэл эсийн эмчилгээний асуудлыг ч бас оруулж өгч байгаа. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 5 үүдэл эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээ хийдэг эмнэлгүүд байгаа. Түүнээс өнөөдрийн байдлаар 5 мянга орчим хүн гэр бүл үрийн зулай үнэрлэж, баяр хөөртэй байгаа. 5 мянга гаруй хүүхэд үр шилжүүлэн суулгах эмчилгээний дараа төрсөн байна. Асуултад хариуллаа.

Л.Энхнасан: Тодруулга Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Нэмэлт 2 тодруулга хэлье. Энэ эрхтэн арилжааны хэлбэрт шилжчих вий гэж болгоомжлох уу? Хууль, эрх зүйн хуульд хамгаалалт нь ямар байх вэ? Донор хүлээж байгаа, хайж байгаа гэсэн ийм яриа аман хэлбэрээр энэ ийм

эрхтэн шилжүүлэг суулгах тэр элэг, бөөртэй холбоотой хүмүүс яригдаж байдаг шүү дээ. Энэ арилжааны хэлбэрт 1 дүгээрт шилжих вий.

2 дугаарт энэ донор хүлээж буй иргэдийн хувьд нөөцийн шударга хуваарилалт байж чадах уу? Нөгөө амьгүй донороос шилжүүлье гэсэн ийм бас процент хуулийн зохицуулалтууд энэ дотор байна шүү дээ. Тэгэхээр энийг яг шударга хуваарилалт, нөгөө хуваарь юм уу, жагсаалтад орж хүртээмжийг нь яаж уян хатан байдлаар шийдэх вэ?

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Манай алба 2018 онд байгуулагдсанаас хойш энэ сошиал ертөнцөд эрхтэн зарна, эрхтэн худалдаж авна гэдэг асуудлуудтай нэлээн танилцаад л, Эрүүгийн цагдаагийн газрын Цахим гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтарч ажиллаад энэ асуудлуудыг ерөнхийд нь зогсоосон байгаа. Энэ сошиал ертөнц дээр тавигддаг асуудлуудыг нэлээн хязгаарлаж өгч байна. Ийм юм төрлийн асуултууд тавигдахыг нь бол хориглосон байгаа. Ер нь бол манай хуулийн төсөлд ДЭМБ болон Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг, Станбулын тунхаглалын үндсэн зарчмуудыг мөрдлөг болгосон. Энэ нь бол хүн болон хүний эрхтний наймаанаас сэргийлэх зарчмуудыг бол сайн оруулж өгсөн байгаа.

Хүлээх жагсаалт шударга болдог уу гэдэг асуудал байна. Энэ дээр бол манайх өнөөдрийн байдлаар 31 бодит амьгүй донороос нийтдээ 75 хүнд эрхтэнд шилжүүлэн суулгах эмчилгээ, 173 хүнд шөрмөс шилжүүлэн суулгах эмчилгээнүүдийг хийсэн. Энд бол яг эрхтний хуваарилалт дээр манай алба болон багууд хамтраад энэ хүлээх жагсаалтаас бол тухайн цусны бүлгийн дарааллаар нь хүмүүсийгээ хүлээх жагсаалтад байгаа хүмүүсийгээ дуудаж уулзаж, тэр дотроосоо хамгийн илүү их зохицож байгаа эд нийцлийн тохироо нь зохицож байгаа хүмүүсийг багийн гишүүд олноороо хамтарсан сууж сонгодог. Энэ нь бол ирээдүйд бид нэгдсэн бүртгэл мэдээний сан дээрээ бол энэ ухаалаг асуудлыг оруулж өгнө. Тэр нь бол cross matching буюу тухайн хүнд цусны бүлгээрээ орж ирж байгаа эрхтнийг шууд хуваарилдаг ийм программыг бид үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Саранчулуун гишүүн асуултаа асууна.

О.Саранчулуун: Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт дээр Био банк гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэл, хяналт хийх зорилгоор авсан эд, эсийг хадгалах тусгай зориулалтын санг хэлнэ гэж байгаа юм. Яах вэ би нөгөө 2, 3 хуудаснаас харахаар судалгаатай холбоотой ганцхан үг эндээс л харах шиг болов уу. Бусад нь хараагүй бол тодруулъя. Тэгэхээр энэ судалгаа гэдэг дээр ямар агуулгыг оруулж байгаа юм бол, юуны тухай асуудал вэ 1 дүгээр асуудал нь?

2 дугаар асуудал нь өнөөдрийн манай Био банк, Монголд байгаа Био банкны нөхцөл байдал ямаршуу байдалтай байна вэ гэдэг талаар мэдээлэл өгөхийг хүсэж байна?

3 дугаарт нь цогцос дээр сургалт, ер нь яах вэ анагаахын сургуулиуд, мэс заслын ер нь сургуулиуд цогцос дээр судалгаагаа хийж, сургалтаа хийж ингэж явдаг.

Тэгээд цогцос ер нь олдохоо байчихсан гэж сүүлийн үед ярьж байгаа. Тэгээд мэргэжлийн хүмүүс нь байгаа учраас би энэ дээр тайлбар сонсчихъё гэж бодоод байгаа юм. Ер нь энэ донорын эд, эрхтэн, эд, эсийг сургалттай холбоотой ашиглах зохицуулалт энэ хуулийн төсөлд орсон уу гэдэг дээр тодруулъя? Тэгээд дараа нь санал яаж өгөх билээ даргаа? Сүүлд нь саналаа өгөх болов уу?

Л.Энхнасан: Баярлалаа. Тэгэхдээ зарчмын зөрүүтэй санал 2 хоногийн өмнө байгаа. Одоо уул нь 1 дүгээр асуудлаа ярьж байгаа. Тэгэхдээ 4 дүгээр зүйл дээр асуулаа. Тэгэхдээ дэд хорооноос, ажлын хэсгээс хариулна уу, хэн хариулах вэ? 7 дугаар микрофон Алтантулга хариулах уу.

Б.Алтантулга: Сайн байна уу. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах албаны дарга Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Бид энэ хуулийн төсөлдөө Био банкны асуудлыг нэлээн сайн оруулж өгсөн. Энэ дээр ялангуяа бэлгийн эсийн Био банкны энэ асуудлыг бол бид дотооддоо эмнэлэг тус бүр дээрээ байгуулъя гэж ярьсан. Яг эсийн энэ банк, эсийн сангийн асуудлыг бол манай эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан байгууллага дээрээ энэ асуудлыг зохицуулахаар бол тусгасан байгаа.

Дараа нь судалгаа шинжилгээний асуудал мөн био банкны энэ асуудал дээр энэ эрхтэн, эд, эсийн судалгаа шинжилгээний зорилгоор авч ашиглах үйл ажиллагааны зохицуулалт, тэдгээрийн харилцааг нарийвчлан тусгаж өгсөн.

Сүүлийн асуулт нь болохоороо бид одоохондоо энэ цогцос дээр сургалт хийх энэ асуудал бол яах вэ олон улсад байдаг нь болохоороо body донор гэж энэ асуудал байдаг. Тэгэхээр манай энэ хууль маань яг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа учраас бид яг энэ цогцсыг яг сургалтад ашиглах энэ асуудал бол тусгагдаагүй байгаа.

Л.Энхнасан: Тодруулга Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Ер нь цогцос дээр сургалт дадлага хийгээгүй мэс заслын эмч ямар юм сурах вэ гэдгийг та бүхэн бас эргэцүүлж бодож байгаа байх. Тэгэхээр яах вэ дараагийн түвшинд жишээлбэл энэ хуулийн дараагийн level гэдэг юм уу даа түвшинд ахиж энийгээ оруулж ирэх юм уу, ахиж яригдах уу? Анагаахын аягүй олон эмч хүмүүс байгаад байдаг, тэгээд л мэс засал хийлээ, тэгээд зарим нь буруу оношлогдлоо гээд асуудал байгаад байдаг шүү дээ. Тэгэхээр үүний чинь цаана сургалтын хэрэглэгдэхүүн гэдэг асуудал яригддаг. Сургалтын хэрэглэгдэхүүн дотор нь мэдээжийн хэрэг технологи байгаа ч гэсэндээ зайнаас, алсаас дадлага хийх нэг өөр, технологи дээр дадлага нэг өөр, ер нь бодит бие цогцос дээр дадлага хийх өөр гэж мэс заслынхан өөрсдөө бас ярьдаг юм билээ. Тэгэхээр энийг ер нь дараагийн шатад үндэсний төлөвлөгөө ч байдаг юм уу, дараагийн шатад нэг ийм оруулж ирнэ, яригдаж байгаа ч гэдэг юм уу ийм асуудал байгаа юу? Ер нь яригдаж байгаа ийм бодлого, хууль, эрх зүйн баримт бичгийн ноорог ч болтугай юм байгаа юу? Тэр талаар л мэдээлэл авмаар байгаа юм.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн дарга Баярбаатар гишүүн хариулна уу.

Б.Баярбаатар: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Ер нь таны ярьж байгаа асуудал их чухал. Өмнө нь энэ оюутнууд яг энэ цогцос дээр дадлага хийдэг байсан, одоо больсон. Тэгэхдээ яг энэ манай хуулийн хүрээ хязгаарт хамаарах уу

гэдэг асуудал энэ сургалт, судалгааны асуудал чинь. Бид энэ эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах, амьд донор, амьгүй донор гэсэн ийм харилцааг зохицуулах хуулийн төсөл учраас магадгүй таны ярьж байгаа зүйл манай хуулийн хүрээ хязгаарт яг орох уу, цаашлаад бусад хуулиуд дээр орох уу. Таны саналыг бүрэн дэмжиж байна. Хэрвээ манай хуулийн хүрээ хязгаарт орж болно гэж үзвэл оруулчихмаар байгаа юм. Хараад үзэхээр бол яг хамаарахгүй л харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бусад хууль тогтоомж дээр харин энийг оруулах ийм боломж бололцоо байгаа шүү. Олон оюутнуудтай би уулзсан. Яг энэ асуудлыг ярьдаг юм байна лээ мэргэжлийн байгууллагынхан, тийм.

Л.Энхнасан: Батчулуун зөвлөх нэмж хариулна уу, 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Энэ асуудал анх бүр 2018 онд энэ Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед бид ажлын хэсэг дээр энэ body donation-ний асуудлыг оруулж ирж байсан юм. Энэ нь бол бусад улс, өндөр хөгжилтэй орнуудад бол body donor law гээд тусдаа биеэ даасан хууль байдаг юм байна лээ. Тэгэхлээр бол бид энэ хуульдаа энэ талаар тусгаагүй. Ирээдүйд бол энэ асуудлыг илүү нухацтай судлаад, ингээд оруулж ирэх бололцоотой гэж бодож байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Тийм, тэгэхлээр нөгөө 1 дүгээр зүйл. Хуулийн төслийн нэрийн “ЭРХТЭН, ЭД, ЭС” гэсний өмнө “ХҮНИЙ” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Баясгалан, Энхнасан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат цаашид ажлын хэсэг гэх. Бумба-Очир гишүүн. Чинбүрэн гишүүн сая бол саналаа ер нь мэргэжлийнхээ саналаа хэлчихлээ шүү дээ. Тэгээд тэрийг бодолцоод санал хураалтдаа оролцоно уу? Эрдэнэбат гишүүн горимын санал гаргая гэж байна.

С.Эрдэнэбат: Чинбүрэн гишүүний тавьсан саналыг ойлгож байна. Ер нь энэ хууль технологи гэдэг маш хурдацтай явж байна гэдгийг. Гэхдээ зүгээр яг санал хураахаас өмнө нэг горимын санал хэлэхэд магадгүй энийг нөгөө хүний гэдгийг нь ингээд орхичоод амьтны юмыг давхар зохицуулалтыг энэ хуульд амьтан гэдэг үг ерөөсөө байхгүй байгаа. Тэгээд тэр зохицуулалтуудыг яах вэ, хэрэгтэй болох уу, яах вэ, ийх вэ гэдэг нэг ийм асуудал байна тийм үү? Энэ хуулийг ашиглаад амьтнаас шилжүүллээ гэж бодоход ямар амьтнаас, хаана хадгалаад, яаж авах юм, тэр хүнээс нь ямар зөвшөөрөл авах юм, чамд амьтны тодорхой эрхтнийг шилжүүлэх гэж байгаа гэдгийг нь хэлэх ёстой юм уу, үгүй юм уу гэдэг ийм зохицуулалтуудыг нөгөө яриагүй учраас ийм юм гарч ирэх болов уу л гэдэг ийм бодол байна.

Түүнээс биш би энэ зарчмын саналыг дэмжиж байна. Шинжлэх ухааных нь хувьд ингээд амьтнаас шилжүүлдэг зөндөө технологи байж байхад магадгүй жилийн дараа гэхэд манайд ороод ирэх тохиолдолд хуулиа өөрчлөх үү гэдэг юм хүртэл гарч ирж болзошгүй учраас энийг харин яах вэ гэдэг юмыг би тодруулж асуумаар байна.

Л.Энхнасан: Яах вэ нөгөө ажлын хэсэгт та өөрөө бас орж байгаа шүү дээ. Бид энэ асуудлыг зөндөө ярьж байгаад ингээд нэмье гэсэн. Хэрвээ ингээд дэмжигдэхгүй бол, дэмжихгүй гээд бодож өгвөл дэмжихгүй байж болно. Тэгэхдээ ажлын хэсгийн дарга хариулчих уу? Тийм саналаа л хураачихъя. Хэрвээ энэ нөгөө гэж нэмэх гэдэг томъёоллоор дэмжвэл хүнийг гэж орно, дэмжихгүй бол хуучнаараа байна л гэсэн үг. Тийм. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа

бэлдсэн үү? Хуулийн төслийн нэрийн “ЭРХТЭН, ЭД, ЭС” гэсний өмнө “ХҮНИЙ” гэж нэмэх. Санал хураалт. 18 гишүүний 18 нь дэмжсэнгүй. Тэгэхлээр нөгөө тэгээд хуучнаараа үлдэнэ гэсэн үг. Энэ санал дэмжигдсэнгүй.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна. Санал хураалтдаа бэлдье. Биш үү, цаашаа шууд явчих уу.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Ажлын хэсэг саналтай. Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явах, шууд явах уу? Санал хураалт, дэмжье гэсэн санал хураалт. 18 гишүүнээс 13 гишүүн дэмжлээ, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтдаа бэлдье. Тийм бэлдэхгүй тийм ээ, шууд санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 4.1.3.амьгүй донор гэж, алгасчихсан шүү, уучлаарай.

4 дэх Төслийн 1 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнөх “хүний” гэснийг хасаж, 4.1.2 дахь заалтын “бөгөөд гэрлэгчид, төрлийн хүн, садангийн хүн, хүргэн, бэр гэсэн дарааллаар сонгогдсон хүнийг” гэснийг “, хүргэн, бэрийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.3.“амьгүй донор” гэж тархины үйл ажиллагаа бүрэн, эргэшгүй алдагдсан, тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэл нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгахаар авч болох донорыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал асуух, Ганбаатар гишүүн асуултаа асууя.

А.Ганбаатар: Энэ 4.1.3 дээр амьтай донорыг бол ойлгож байна. Амьгүй донор гэдэгт аваар осолд ороод, эмнэлэгт хүргэгдээд, тэгээд тархины үйл ажиллагаа нь зогссон, зүрх болон бусад эрхтнүүд нь ажиллаж байгаа үед шилжүүлэн суулгахыг хэлж байгаа тийм ээ. Гэхдээ хүн гэнэтийн ослоор явчихна гэж бодохгүй явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ зөвшөөрлийг нь яаж авах юм бэ?

Л.Энхнасан: Ажлын дарга Баярбаатар гишүүн хариулна уу.

Б.Баярбаатар: Ер нь тархины үхэлтэй донор буюу амьгүй донор. Автын осол, гэнэтийн осол, янз бүрийн, дээр нь өнөөдөр тархины цус харвалт гээд олон шалтгаанууд байж байгаа. Зөвшөөрлийн хувьд бол хууль дээр зохицуулалт хийчихсэн байгаа. Өмнө нь 3 хүртэл гэдэг байсан юм, 3 хүртэл гэр бүлийн гишүүд

нэг хүн ч зөвшөөрч болохоор байхгүй юу. Одоо хууль дээр 3 гээд яг заачихсан, 3 хүний зөвшөөрлийг авна.

Нөгөө талаар өнөөдөр амьд сэрүүндээ өнөөдөр би донор болно гэдэг зөвшөөрлийг иргэн хүн өөрөө ИМонголиагаар ороод бүртгүүлэх боломж нээгдэж байгаа. Одоогоор 6500 орчим хүн би донор болохыг зөвшөөрч байна гээд ингээд үнэмлэх авчихсан байдаг. Энэ тодорхой түвшинд зохицуулалтуудыг нь ингээд хийгээд явж байгаа гэдэг зүйл байгаа. Зөвшөөрөл олгогдоогүй хүн бол гэр бүлийн гишүүдээс нь 3 хүнээс зөвшөөрөл авч, тийм. Хойшоо заалт дээр зохицуулалт нь байгаа. Санал хураагдана бас, тусдаа зохицуулчихсан.

Л.Энхнасан: Тодруулга Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Гаднын оронд жолооны үнэмлэх дээр нь ингээд тавьчихдаг шүү дээ зүрхний зурагтай, түүн шиг тийм байж болох уу л гэж байгаа юм. Зүрх зогсохоор нь гэр бүл рүү нь утасдвал утас нь хаалттай байвал яах вэ гэж. Би зүгээр их энгийн марзан юм асуугаад байж магадгүй. Гэхдээ энийг нэг тодорхой болгохгүй бол амьгүй донорын эрх гэж байна шүү дээ тийм ээ. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярбаатар гишүүн хариулна уу.

Б.Баярбаатар: Донор болохоор зөвшөөрсөн иргэн хэн ч байсан гэсэн өөрөө зөвшөөрөл олгосон тохиолдолд үнэмлэх авч байгаа, үнэмлэх олгож байгаа. Хэзээ ч энэ донор болохоосоо бас татгалзаж болно, зөвшөөрч болно, хэдий хугацаанд ч гэсэн бас татгалзаж болно. Тэгэхээр энэ зохицуулалтыг хуульдаа хийгээд өгчихсөн байж байгаа.

Л.Энхнасан: Бумба-Очир гишүүн асуултаа асууна.

Д.Бум-Очир: Баярлалаа. Энэ амьгүй донор гэдэг нэр томъёоны тодорхойлолт дээр асуух гэж байгаа юм. Тархи зогссон үед гэгчихсэн байгаа. Тэгээд яах вэ ингээд уншихаар зүрх зогсоогүй байж болох юм байна гэж ойлгосон. Тэгээд яах вэ олон улсын практик бол тархи зогсчихсон, зүрх зогсоогүй ч гэсэн хуульд нь, шинжлэх ухаан нь ч амьгүй гэж үздэг юм шиг байна. Гэхдээ бас жаахан маргаантай байдаг бололтой. Бидний хувьд энгийн хүмүүсийн хувьд зүрх зогсоогүй байхад зөвхөн тархи нь зогсчихсон байхад амьгүй гэж нэрлэх чинь ёс заншлаа ч юм уу, Монгол хүний талаасаа бодсон ч гэсэн жаахан эвгүй л дээ. Тэгэхээр энийг яах юм бэ? Магадгүй яг ороод ирдэг зүрх нь зогсоогүй байдаг, тархи нь зогсчихсон байдаг, тэр ар гэрийнхэн нь тэр хүнээ амьд л гэж үзнэ шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ дээр нэг тийм харилцааны, танин мэдэхүйн, ёс зүйн, итгэл үнэмшлийн янз бүрийн асуудал юм гарах болов уу гэж бодож асууж байгаа юм.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн дарга хариулъя, дараа нь Батчулуун зөвлөх бас хариулъя.

Б.Баярбаатар: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Яах вэ амьгүй гэдэг үгэнд л эмзэглээд байгаа. Ер нь энэ олон улсын хэллэг. 1966 оноос хойш хэрэглэгдэж байгаа. Тархины үхэл гэдэг маань өөрөө тархины үйл ажиллагаа нь зогсож, эргэж сэргэхгүй болсныг. Энийг тогтоодог тусдаа баг бүрэлдэхүүн байгаа. Донор болох хэмжээнд үйл ажиллагааг нь, донор болох хэмжээнд тогтоох ийм баг бүрэлдэхүүн тодорхой зардал мөнгөөр тухайн хүнийг бусад эрхтнүүдийг нь

ажиллуулах ийм үйл ажиллагааг явуулна л гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр таны хэлж байгаа бол амьгүй гэдэг үгэн дээр эмзэглээд байгаа. Гэтэл энэ маань яг энэ 4.1.3 гэдэг энэ хуулийн томъёолол маань дэлхийд хэрэглэгдэж байгаа энэ үг хэллэгээрээ ингээд ороод ирчихсэн байгаа гэдгийг бас хэлье. Тийм.

Л.Энхнасан: Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон нэмж хариулья.

П.Батчулуун: 1968 онд энэ Харвардын их сургуулийн эрдэмтэд энэ тархины үхэл гэдэг тодорхойлолтыг бий болгоод, энийгээ бол хэлэлцүүлээд, энэ нь тархины үхэл бол биологийн үхэл буюу хамгийн жинхэнэ үхэл гэдэг юм criteria гаргаж ирсэн. Энийг хэрхэн тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийг нь гаргаж ирсэн юм. Ингээд энэ нь дэлхий нийтээр өнөөдөр мөрдөж байгаа юм. Түрүүний гишүүний хэлсэн тэр зүрх нь ажиллаж байна, уушги нь ажиллаж байна гэдэг. Тархины гэмтэлд ороод тархи нь гэмтээд юм уу, эсвэл тархинд нь цус харваад ингэхлээр хүн өөрөө амьсгалж чадахаа байчихдаг. Тэгэнгүүт тэрийг нь бол зүрх болон амьсгалыг эмийн хүчээр ажиллуулж байж, тэгээд тэр донор болгох бололцоог нь нээж өгдөг юм. Тийм учраас тархиндаа гэмтэл авсан хүн бол тархинд үхчихвэл 2-оос 3 минутын дараа зүрх нь зогсоно, тэгээд л амьсгал зогсоно. Тийм учраас энийг нь хиймлээр ажиллуулж байж бид донор болгох үйл ажиллагааг явуулдаг юм.

Л.Энхнасан: Баярлалаа. Асуулт асууж дууслаа. Би бас нөгөө ЭМЯ-ан дээр нэг сайдад, төрийн нарийнд анхааруулж нэг юм захъя. Энэ амьд болон амьгүй донорын бүртгэх, эрхтэн, эд, эс авах, шилжүүлэх, сонгох, хуваарилах, боловсруулах, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, энэ шилжүүлэн суулгах, хянах, устгах гэсэн ийм журам байдаг. Энэ хууль батлагдсантай холбогдуулаад энэ журмыг маш яаралтай шинэчлээрэй. Яагаад гэвэл өмнө нь энэ асуудал урьд нь гарч байсан энэ нөгөө Донорын хууль маань батлагдчихсан байгаад байдаг. Яамны журам бол шинэчлэгдээгүй бас нэлээн удсан. Тэгэхлээр энэтэй холбогдуулаад энэ дээр ЭМЯ анхаарна уу. Баярлалаа. Санал хураалт. 18 гишүүний 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг “эсхүл” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “эсийг шилжүүлэн суулгах” гэсний өмнө “үүдэл” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.“реципиент эмнэлэг” гэж бүтцэд нь төрөлжсөн тасаг, мэргэжлийн багтай Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” гэж санал гаргасан ажлын хэсэг, тийм биз дээ. Санал хураалт. Саранчулуун гишүүн асуулт асууя гэж байна. Саяынхыг. Асуултаа асуучих, энийг дараа нь хэлчихье.

О.Саранчулуун: Би энэ 4.1.7 дээр асуух гээд байна л даа. Бүтэц нь төрөлжсөн тасаг, мэргэжлийн багтай Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 13-д заасан эрүүл мэндийн байгууллага. Ийм байгууллага манайд яг хувийн хэвшилд хэд, улсын хэвшилд хэд байгаа гэдэг тоог нь зүгээр ажлын хэсгээс асуучихъя тэгэх үү? Баярлалаа.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон.

М.Наранпүрэв: ЭМЯ, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар Наранпүрэв байна. Реципиент эмнэлэг гээд энэ бүтцэд төрөлжсөн тасаг гээд тэгэхлээрээ эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тасагтай, мэргэжлийн баг гэхээрээ тухайн эд, эрхтнийг шилжүүлэн суулгах мэргэжлийн багтай эмнэлэг хувийн эмнэлгийн тухайд одоогоор байхгүй байгаа. Энэ 15.1.11, 15.1.13 нь төрөлжсөн нарийн мэргэжлийн лавлагаа шатлалын эмнэлгүүдийг заасан байгаа.

Л.Энхнасан: Яг тодорхой тоог нь асуугаад байх шиг байна. 4 дүгээр микрофон. Батчулуун зөвлөх гэсэн үү, 4 дүгээр микрофон гэсэн үү, хэн хариулах гэж байна вэ? Наранпүрэв дарга.

М.Наранпүрэв: Одоогоор 5 эмнэлэг байгаа. Улсын 1 дүгээр төв эмнэлэг, Улсын 2 дугаар төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Улсын 3 дугаар төв эмнэлэг, 2 дугаар төв эмнэлэг гээд 5 эмнэлэг дээр үндсэн үйл ажиллагаа явуулж байна. ХСҮТ орно.

Л.Энхнасан: Баярлалаа. 18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.8.“донор эмнэлэг” гэж амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: 15.1.11, 13 бол манай төрөлжсөн 3 дугаар шатлалын ийм эмнэлгүүд юм байна. 15.1.7 гэдэг чинь ямар эмнэлэг орж ирэх билээ?

Л.Энхнасан: Ажлын хэсэг хариулах уу? 4 дүгээр микрофон Наранпүрэв дарга.

М.Наранпүрэв: Энэ аймгийн нэгдсэн эмнэлгүүд, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эмнэлгүүд үүнд хамаарч байгаа. Тэгээд лавлагаа шатлалын бусад эмнэлгүүд бүгд хамаарна гэсэн үг.

Л.Энхнасан: Эдгээр нь донор эмнэлэг болно гэсэн л үг шүү дээ. Дэмжье гэсэн санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.11.“био банк” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор авсан эд, эсийг хадгалах тусгай зориулалтын санг;” Санал гаргасан ажлын хэсэг. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Судалгаа гэдгийг нь тодруулъя. Яагаад гэвэл би судалгаа гэж байгаа бол сургалт гэдэг агуулгыг бас байх ёстой л гэж үзэж байна. Тэгэхээр судалгаа гэдэг дээр яг ямар төрлийн судалгаанд энэ сангийн эд, эс хэрэглэгдэх юм бэ гэдгийг тодруулъя.

Л.Энхнасан: Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон хариулна уу.

П.Батчулуун: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Батчулуун. Энэ ер нь бол энэ Био банканд хамгийн гол нь эд нийцлийн тохироо үзүүлэхээр хүлээх жагсаалтад байгаа хүмүүсийн цусны бүлгийн дэс дарааллаар бол энэ бас цусны энэ sample-г авч хадгалдаг. Энэ дээр манай эрхтэн шилжүүлэн суулгах багуудаас бол энэ хүлээх жагсаалтад байгаа улсуудынхаа цусны бүлгийн эд нийцлийн тохироонуудыг судалгаанд бас авч ашигладаг байгаа. Энэ дэлхий дээр бол өргөн дэлгэр байдаг.

Түүнээс гадна бид энэ био банканд арьс болон нүдний эвэрлэг, зүрхний хавхлаг, ясны чөмөг, шөрмөс хадгална. Тэгэхлээр бол энэ яалт ч үгүй судалгаанд орохоос өөр замгүй болно. Яагаад гэвэл энд хадгалагдаж байгаа эдүүд маань шилжүүлэн суулгах эмчилгээнд орохоос өмнө энэ тухайн хүнтэйгээ реципиенттэйгээ тохирч байгаа хэсгүүдийг судалдаг ийм байгаа. Тэгэхлээр бол энэ дээр лабораторийн энэ био банкиг ажиллуулах асуудал бол нэлээн төвөгтэй. Ер нь төрийн болон хувийн хэвشلүүд дээр байдаг. Гэхдээ бол маш их зардалтай байдаг учраас тэр болгон эмнэлгүүд хийж чаддаггүй ийм байгаа юм.

Л.Энхнасан: Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.17 дахь заалтыг хасах:

“4.1.12.“эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлгийн нөхцөлд донорыг илрүүлэх, эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, шилжүүлэн суулгах болон мэс заслын дараах эмчилгээ, хяналт хийх эмнэлгийн тусламж, үйлчилгээг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.17 дахь заалт нэмэх:

“4.1.17.“сорьц” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор хүнээс авсан цус, эс, эд, эрхтний хэсгийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.18 дахь заалт нэмэх: хүйд эс гэж,

“4.1.18.“хүйн эд” гэж нярайн хүй таслагдсаны дараа ихэстэй залгаа хэсгээс тайран авсан хүйн судсан багцыг;” уучлаарай, энэ нөгөө мэргэжлийн үгнүүд байгаа болохлоор алдаад байж байгаа юм. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.19 дэх заалт нэмэх:

“4.1.19.“үндэсний хүлээх жагсаалт” гэж эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийг эрхтэн, эд, эс, цусны бүлгээр ангилан, эмнэл зүйн үнэлгээ, шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн бүртгэсэн жагсаалтыг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сайн дурын,” гэсний дараа “аливаа дарамт шахалт, бусдын нөлөөнд автахгүй” гэж нэмж, мөн зүйлийн 5.1.6 заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн хоёрдугаар бүлгийн гарчгийн “ДОНОРЫГ СОНГОХ” гэснийг “ДОНОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагаас” гэж нэмж, мөн заалтын “холбогдох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагаас” гэснийг хасах. Ажлын хэсэг, санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “холбогдох журам, зааврын дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “, хүүхэд” гэснийг “гаргах бөгөөд, хүүхэд, эрх зүйн бүрэн чадамжгүй иргэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж нэмж, 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасаж, мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Би сая өөрөө дарж амжсангүй. Горимын санал гаргаж байна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү. Санал хураалт. 61,1 хувиар сая саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Дэмжье гэсэн санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсрол харгалзахгүйгээр иргэн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалуулах” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр хүн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалах” гэж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “хангах” гэснийг “сайжруулах” гэж өөрчилж, мөн заалтын “тусламж, үйлчилгээг” гэсний өмнө “эрүүл мэндийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтын “сайн дурын үндсэн дээр” гэснийг “сайн дураар” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэцийн эмгэггүй” гэсний өмнө “хөгжлийн бэрхшээлгүй хүн болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулан эрхтэн, эд, эсээ өгөхдөө” гэнийг, мөн зүйлийн 8.1.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.Эсийн донор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.2.1.эсийн донорт насны дээд, доод хязгаар заахгүй, хэрэв бэлгийн эсийн донор бол 18 насанд хүрсэн байна;

8.2.2.хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр авна;

8.2.3.эсийн донор нь гэр бүлийн гишүүн эсхүл сайн дурын донор байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай эцэг, эх болон асран хамгаалагчийн зөвшөөрлөөр гэсэн байх юм. Тэгэхээр энэ хүүхдээс энэ 14 насыг ямар хууль, эрх зүйн үндэслэлээр энэ насыг 1 дүгээрт сонгосон юм гэдгийг?

2 дугаарт энэ чинь Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай нэлээн олон зүйл, заалттай зөрчилдөөд байгаа заалт шиг харагдаад байх юм. Тэгэхээр энэ дээр тодруулга авах хэрэгтэй байна.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 7 дугаар микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах албаны дарга Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Манай хуулийн төсөл дээр энэ заалт маань өмнө мөрдөгдөж байсан Донорын тухай хуулийн энэ төсөл дээр, өмнө мөрдөгдөж байгаа, одоо мөрдөгдөж байгаа Донорын тухай хууль дээр хүчин төгөлдөр хэрэгжээд явж байгаа. Энэ маань бол ялангуяа ясны хавдрын үед тухайн гэр бүлийн гишүүдээс нь хамгийн тохирох донор нь ах, дүү нар нь байдаг. Тэгээд эдгээр өндөр тохироотой донор нь ихэвчлэн өвчтөний буюу эмчлүүлэгчийн ах, дүү байдаг. Тэгээд эдгээр нь бол ихэвчлэн бага насны хүүхдүүд хэрвээ байвал энийг бас донор болгоё гэдэг л энэ заалт. Энэ нь мөн одоо хэрэгжиж байгаа.

Ялангуяа энэ бид энэ шинэ хуулийн төсөл дээрээ илүү нарийн тодруулсан нь 14 хүртэлх настай бол яг эцэг эх болон асран хамгаалагч, 14-өөс дээш настай өөрийнх нь зөвшөөрлийг нэмж авъя гэдэг энэ заалтыг нэмж тусгасан байгаад байгаа юм. Яаж авдаг техникийн хувьд тайлбарлавал энэ бол 2 аргаар авна. Нэг нь болохоороо захын цус руу үүдэл эсийг ялгаж гаргаад үүнээсээ үүдэл эсийг нь эмчлүүлэгчид шилжүүлэн суулгана. Нөгөө нэг арга нь болохоороо ясны хэмд хатгалт хийгээд үүдэл эсийг гаргаж аваад шилжүүлэн суулгадаг. Ихэвчлэн бага насны хүүхдүүдэд болохоороо захын цус руу үүдэл эсийг ялгаад, үүнээсээ яг бид

энгийн цусны шинжилгээ өгч байгаа юм шиг цусыг нь аваад эргүүлээд үүдэл эсийг нь ялгаад ингээд шилжүүлэн суулгадаг технологи байгаа.

Л.Энхнасан: Саранчулуун гишүүн тодруулга хийе.

О.Саранчулуун: Би хүүхдийн эрхийн асуудлыг яриад байгаа юм. Хүүхэд өөрөө зөвшөөрөхгүй бол яах юм бэ? Энэ дээр чинь 14-өөс хүртэлх настай бол эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл гээд байгаа байхгүй юу. Тэгээд хүүхэд өөрөө зөвшөөрөхгүй байвал ээж аав нь зөвшөөрөөд өгүүлчих тухай юм шиг уншигдаад байна шүү дээ. Тэгэхээр энийг тодруулах гээд байна л даа. 14-өөс доош насны хүүхэд өөрөө зөвшөөрөхгүй гээд байхад ээж аав нь зөвшөөрсөн юм гээд хатгачих юм уу л гэдэг асуудлыг асуугаад байна шүү дээ.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Ер нь энэ 14-өөс өмнөх насны хүүхдүүд өөрсдөө яг өөрийнхөө хүслийг илэрхийлэх чадвар муутай байдаг гэж үзээд заавал эцэг эхээс нь хамтад нь зөвшөөрлийг нь авна гэж байгаа юм. Хэрвээ мэдээж хэрэг тухайн хүүхэд би ийм шинжилгээнд ормооргүй байна гэвэл нөгөө тэрийг харгалзаж үзэх нь ойлгомжтой.

Л.Энхнасан: Яах вэ яагаад бас 14 гэж яг үзсэн юм бэ гээд асуугаад байна. 6 дугаар микрофон нэмж хариулах уу?

П.Батчулуун: 1 дүгээрт энэ цусны чөмгөнд ясны цус, цусны эд, эс, эд, эсийн бойжилттой нэлээн холбоотой байдаг. Энэ бол яг тухайн цус ясны чөмөг шилжүүлэн суулгах багийнхан бол энэ дээр ийм хариулт өгдөг юм байна лээ. Түүнээс гадна нөгөө эрх зүйн өөрөө тэр хүүхэд бол яг биеэ дааж шийдвэр гаргаж чадахгүй байгааг нь харгалзаж үзээд ингээд 14. 14-өөс дээш насных нь бол өөрөөс нь заавал зөвшөөрөл авна гэж байгаа юм. Тэр нь бол тухайн хүүхэд 14 насанд хүрснээс хойш бол энэ дээр бол өөрийнхөө хүслийг илэрхийлж чадна гэдэг ойлголтоор оруулсан байгаа юм.

Л.Энхнасан: Наранбаяр гишүүн асуултаа асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ Саранчулуун гишүүний хөндөөд байгаа бол их бас бодох ёстой зүйл байна. 14 нас гэдэг эрүүгийн хариуцлага хүлээж чадах эсэх, тэрийг гол нь өөрөөр хэлбэл эрх зүйн бүрэн чадамжтай юу үгүй, юү гэдгийг л харж энэ тоог тавьсан юм шиг байна. Гэхдээ хүүхэд өөрөө өөрийнхөө хүсэл зоригийг илэрхийлэх бүрэн чадамжтай нас шүү дээ бас 14, 13, 10-аас дээш болоод ирэхээр. Тэгэхээр энэ дээр нөгөө шууд 14 хүртэл бол өөрөөс нь асуухгүйгээр хийж болно, 14-өөс дээш бол өөрөөс нь асуудаг гэсэн ийм айхтар хатуу ийм юу тогтоолгүйгээр энэ Хүүхдийн эрхийн конвенц эд нарыг харгалзаад өөрөөр арай жоохон найруулах боломж байдаггүй юм уу л гэж би бас хэлэх гээд байна л даа. Тэгэхгүй бол та бид чинь ингэчихдэг, тэгээд энэ ажлын хэсэг асуухаар яг энэ хууль зүйн талаас нь ерөөсөө тайлбарлаж чадахгүй, эмнэл зүйн талаас нь л яриад байна шүү дээ. Тэгэхээр энийгээ нэг та бүхэн өөрөөр найруулаад оруулаад ирээч.

Тэгэхгүй бол нээрээ хүүхдийн эрхийн конвенцууд байна. Өөрийнхөө хүсэл зоригийг илэрхийлэх энэ хүний үндсэн эрх, эрх чөлөө гэдэг юм чинь байж байна шүү дээ. Тэгэхээрээ энэ нөгөө эрүүгийн болоод иргэний эрх зүйн чадамжтай

холбоотойгоор яг шууд ингэж оруулах биш. Энэ чинь хүний эд, эрхтнийг, ясны хэмээс, бас захын цусыг нь авна гэнэ үү, захын цус авна гээд ингэж байна. Тэгэхээр өөрөө үнэхээрийн тарианаас айдаг, янз бүрийн юм болоод ингээд ийм байдаг бол эцэг эх нь хүчээр өгүүлнэ гэдэг юм шиг л юм болчих гээд байгааг та бүхэн анхаарч үзээч. Арай жоохон найруулгын засвартайгаар гэдэг юм уу, зарчмын энэ саналаа түр татдаг юм уу нэг энийгээ янзлах хэрэгтэй л гэж бодож байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн дарга Баярбаатар гишүүн. Боломжтой байна уу?

Б.Баярбаатар: Тийм, гишүүдийн хэлж байгаа саналтай бас зарим тохиолдолд. Яах вэ одоо тэгээд 14 нас гэдэг чинь иргэний эрх зүйн чадамжийн асуудлыг зааж байгаа. 18 нас бүрэн чадамж, хагас чадамжтай нь 14 нас.

Нөгөө талаараа өөрөө зөвшөөрвөл, 14 наснаас доош насны хүүхэд өөрөө зөвшөөрвөл эцэг эхийн зөвшөөрлийг бас авахгүй байж болох уу. Энэ дээр 1 дүгээрт байна шүү дээ мэдээж хүүхэд нь зөвшөөрөхгүй байхад эцэг эх нь зөвшөөрөөд асуудалд хандана гэж бас байхгүй байх л гэж харж байгаа.

Л.Энхнасан: Энийг бас тэгэхдээ ер нь ажлын хэсэг анхаарахгүй бол энэ дарга нөгөө жоохон сайжруулж болох уу?

Б.Баярбаатар: Үгүй ээ үгүй, та хэдийн саналыг тусгаад явж болно. Тийм, тусгаад явж болно. Яах вэ зүгээр процессын хувьд өнөөдөр энэ өөрчлөгдөхгүй байхгүй юу. Дахиж Байнгын хороо хуралдаж энэ асуудлаар дахиж ярилцах л асуудал үүснэ л гэсэн үг болж байгаа юм. Чинбүрэн.

Л.Энхнасан: Чинбүрэн гишүүн тодруулга.

Ж.Чинбүрэн: Асуудал хөндлөө. Тэгэхлээр НҮБ-ын баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцод 3 чухал зүйл байгаад байгаа юм. Нэгд хүүхдийн эрх ашиг 1 дүгээрт байх ёстой энэ 3 дугаар зүйл, заалт. Эрүүл мэндийг хамгаалах эрх нь 24 дүгээр зүйл. Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрх буюу 12 дугаар зүйл. Энэ 3-ыг ингээд гурвууланг нь аваад үзье. Жишээлбэл 14 хүрээгүй хүүхэд яах вэ. Хүрээгүй хүүхэд өөрийгөө бүрэн илэрхийлэх чадамжгүй байгаа учраас түүний хайртай ах юм уу, эгч нь, дүү нь энэ цусны хавдраар нас барах гээд, өвчин зовлондоо нэрвэгдсэн байхад хүүхдүүд энэ чинь зөвхөн өөрийнхөө төрсөн ах, дүүдээ л өгөх гээд байгаа шүү тийм ээ. Тийм учраас энийгээ аврахын тулд би ингэе гэж өөрөө санаачилдаг юм шүү, энэ амьдрал дээр байдаг практик. Тэгэхлээр хүүхдийн эрүүл байх эрх ашгийг бид хамгаалах гэж байгаа шүү нэг. Нөгөө хүүхдийг эрсдэлд оруулахгүйгээр ахыг нь юм уу, дүүг нь аврах гэж байгаа, хүүхдийн эрх ашгийг хамгаалах гээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид конвенц зөрчихгүй.

Эрүүл мэндийг хамгаалах эрх нь гэдэг чинь саяын ярьж байгаа зүйл. Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрх гэдэг дээр бид 14 гэдэг нас бол энэ нөгөө юугаар дэлхий нийтээрээ тогтсон нас учраас бид энийг өөрчилж чадахгүй. Тийм учраас нэмээд 14 нас хүрчихсэн бол өөрөө заавал “за” гэж хэл гэж хэлэх гээд байгаа байхгүй юу. Тэгээд ээж аав нь зөвшөөр гээд байгаа юм. Тийм учраас энэ яг ингээд өвчин туссан, ийм өвчин зовлонтой улсуудын гэр бүлд тохиолддог явдлыг яг ийм том зургаар нь та бүхэн харахыг бодоорой. Түүнээс хүүхдийг зүгээр аваачаад л хатах гэж байна гэж битгий бодоорой. Энэ аягүй emotional сэтгэл зүйн дарамттай, гэр бүлийн асар их процесс болж байгаа. Тэгээд энд хамгийн тохирч байгаа тэр

хүүхэд тэр ах нь ч юм уу, дүү нь ч ч юм уу хэн байх юм. Тэгээд тэр 14 нас бол илүү бүрэн гүйцэд бойжсон гэж үздэг бас яг шинжлэх ухаан талаасаа бол. Тэр нь илүү их 14 наснаас дээш бол илүү сайн л гэж хэлэх гээд байхгүй юу. Харин энэ зөвшөөрлүүдийг зөв авахгүй байвал хүүхдийн конвенцыг зөрчинө гэсэн үг. Нэг ёсондоо 14 нас хүрээгүй байхад нь эцэг эхээс нь асуулгүй, албадах, шаардах, шахах. 14 нас хүрчихсэн байхад нь өөрөөс нь бас зөвшөөрөлгүйгээр зөвхөн эцэг эх нь хэлж бас болохгүй л гэсэн санаа шүү. Тийм учраас бид энэ.../минут дуусав/

Л.Энхнасан: Наранбаяр гишүүн тодруулга.

П.Наранбаяр: Уучлаарай энэ дээр бас яах вэ ойлгож байна, ойлгож байна. Тэр 14 настай хүүхдийн эрх зүйн бүрэн чадамжийн асуудал яригдаад байгаа. Тэгэхээрээ зэрэг жоохон найруулгын хувьд, хууль бичилтийн хувьд шууд ингээд хар, цагаан гэдэг шиг оруулалгүйгээр, би зүгээр ийм санал оруулах гээд байна л даа. Асуулт гэх үү, санал гэх үү. Хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэж, эцэг эх болон асран хамгаалагчийн гэж таслал. Тэгээд зүгээр хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэж гэдэг үгийг ядахдаа оруулчихвал бас энэ чинь аливаа юм зүгээр тэгээд л болчихно. Тэгээд яг зөвшөөрлийг нь авах нь эцэг эхээс нь авна. Гэхдээ хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэж гэдэг үг орчиход хэн хэнийх нь шаардлага бол орчих гээд байна шүү дээ. Хэрвээ зүгээр ийм санал оруулж байгаа юм. Та бүхэн бас ярилцаад үзэхгүй юу. Баярлалаа.

Л.Энхнасан: Тэгвэл сая Н.Наранбаяр гишүүний оруулсан саналыг редакцын өөрчлөлт оруулаад, тэгээд дэмжихээр тийм. Тэгэхээр хүндэтгэж. Саяын найруулгыг өөрчлөөд дэмжье гэсэн санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хүүхдээс ясны хэм, хүйн цус, хүйн эд, захын цуснаас бусад эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ,” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол,” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “үйлчилгээ, түүнтэй холбоотой бусад мэдээ” гэснийг “үйлчилгээний талаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Саранчулуун гишүүн. Уначихлаа. Саяын санал, саяын санал гэдэг чинь, саяынхыг хүчингүй болгоод, саяынхыг хүчингүй болгоё. Энэ тэгэхдээ хүчингүй болгоход санал хураалт байх уу? Саяын санал хураалтыг цуцаллаа. Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Уучлаарай нөхөд өө ингээд яг одоо ярихгүй бол өөр ярих юугүй учраас. Энэ 19 ч гэсэн 24 дээр ер нь эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээл гэдэг заалт ерөөсөө байхгүй байгаа. Яах вэ Үндсэн хууль дээр хөгжлийн бэрхшээл гэж тусдаа байхгүй, эрүүл мэнд гэж байдаг байхгүй юу. Тэгэхээр хөгжлийн бэрхшээл маань ерөөсөө орохгүй байгаад байна л даа. Жишээлбэл ингээд эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг гээд, үзэл бодол гэж байна. Нийгмийн, хөгжлийн бэрхшээл чинь нийгмийн гарал биш л дээ. Тэгэхээр та хэд нөгөө эрүүл мэндийн

гэдэг агуулгаар нь хасаад байна уу л гэж би тодруулах гээд байгаа юм. Эрүүл мэндийн нөгөө учраас, хөгжлийн бэрхшээл чинь нөгөө эрүүл мэндийнх учраас тийм.

Л.Энхнасан: Ажлын хэсэг. Энэ нөгөө яг Үндсэн хуулийн бичилтээр яг орсон. Бид бас энэ дээр ажлын хэсгээрээ нэлээн ярьсан. Тэгэхдээ ажлын хэсгийн гишүүд хариулах уу? 7 дугаар микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Бид ажлын хэсгээр ярилцаад энэ амьд донор дээр яг энэ 9.1.1 дээрээ ялгаварлан гадуурхахгүй байх гэдгээ бол Үндсэн хуулиасаа авч тавиад, яг шалгуур дээрээ болохлоороо амьд донор дээрээ хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн байвал амьд донортой байх боломжгүй гэдгийг бол хассан байгаад байгаа юм. Тийм болохгүй гэсэн үг. Энэ дээрээ болохлоороо яг тэр хүний эрх талаасаа Үндсэн хуулийнхаа зарчмыг тавьсан байгаа. Энэ 9.1.1 дэх заалт маань амьд донорын эрх, үүрэг байгаа.

Л.Энхнасан: Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “амьдралын чанарыг хангах тасралтгүй тусламж үйлчилгээг” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар,” гэж өөрчилж, мөн зүйлийн 1.1 дэх 1.1.4 дэх заалтын “мөрдөх” гэсний өмнө “дагаж” гэж нэмэх. Ажлын хэсэг, санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжлээ, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хонжоо,” гэснийг “олох зорилгоор” гэж өөрчилж, “авах,” гэсний дараа “өгөхийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.6, 9.1.7 дахь заалт тус тус нэмэх:

“9.1.6.эрхтэн, эд, эсээ бусдад шилжүүлэн суулгах явцад өөрийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байх эрхээр хангагдах;

9.1.7. эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний явцад технологийн заавар зөрчигдсөний улмаас донорын эрүүл мэндэд хохирол учруулсан нь тогтоогдсон бол эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгасан буруутай этгээд, байгууллагаар хохирлоо нөхөн төлүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлийн гарчгийн “донорт тавигдах шаардлага” гэснийг “донорыг ирүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд амьгүй донороос эрхтэн, эд, эс авна.” Санал гаргасан ажлын хэсэг. Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Тархины үхэлтэй болох нь тогтоогдоно гэж байгаа. Тархины үхлийг тодорхойлох мэргэшсэн баг гэдэгт нь одоо байгаа ямар, ямар баг орох юм

бэ? Тэгээд тархины үхлийг тодорхойлох тэр технологи болон хүчин чадлын хувьд манайд одоо ямар, ямар нөөц бололцоо байгаа юм бэ?

З дугаарт нь энэ хэр хугацаа ордог процесс юм бэ гэдгийг бас тодруулчихмаар байна. Ер нь нөгөө эрүүл мэндийн салбар зөвлөлүүд байдаг шүү дээ. Тэгэхээр энэ эрүүл мэндийн аль салбар зөвлөлд харьяалагдах бас баг байх вэ гэсэн асуултыг тодруулаач?

Л.Энхнасан: Ажлын хэсгээс 6 дугаар микрофон Батчулуун зөвлөх хариулна.

П.Батчулуун: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр манай алба байгуулагдсанаас хойш тархины үхэл тодорхойлох багуудыг нийтдээ Улаанбаатар хотын 7 эмнэлэг, хөдөө орон нутагт 17 эмнэлэг энэ бүсийн оношилгооны төв болон аймгийн эрүүл мэндийн нэгдсэн төвүүд дээр байгуулсан байгаа. Ингээд нийтдээ бол 24 тархины үхэл тодорхойлох баг байдаг. Тархины үхэл тодорхойлох багийг тухайн эмнэлгийн даргын тушаалаар эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар ахлуулсан 5-аас 7 хүний бүрэлдэхүүнтэй ийм баг батлагддаг. Энэ нь бол манай улсын түгээмэл үйлдлийн стандартыг ашиглаж, тархины үхлийг тодорхойлдог байгаа. Энэ тархины үхэл тодорхойлох энэ criteria-г бол 1968 онд Харвардын их сургууль баталсан байдаг.

Одоогийн байдлаар бол, ер нь бол тархины үхэлтэй хүмүүс маань тархиндаа цус харвасан юм уу, тархиндаа гэмтэл аваад тухайн эмнэлэг дээр ирдэг. Тэр үед нь хамгийн эхлээд амь нас аврах үйл ажиллагаа явагдана. Амь нас аврах үйл ажиллагаа явагдаад л энэ хугацаанд амь нас аврах ямар ч боломжгүй гэдэг нь бол батлагдаад, тэгээд тэр хугацаанд тэр хүн маань бусад шинжилгээнүүд дээр донор болох нь боломжтой гэж үзвэл тархины үхэл тодорхойлох багууд тархины үхлийг тодорхойлдог. Эхний удаа энэ баг маань тархины үхлийг тодорхойлсны дараа, 6 цагийн дараа давтан энэ тархины үхлийг тодорхойлдог. Ингэж 2 удаа тархины үхлийг тодорхойлсны дараа бол гэр бүлд нь яг албан ёсоор энэ бол нас барсан гэдэг харамсалтай мэдээллийг өгдөг юм.

Энэ ямар салбар зөвлөлд хариуцагддаг вэ гэхлээр ЭМЯ-ны Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар зөвлөл гэж байгаа. Бас тэгээд энэ тархины үхлийг тодорхойлох багтай холбоотой ЭМЯ-ан дээр байгуулагдсан эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгахтай холбоотой Ёс зүйн хороо бас ажилладаг байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Энэ нөгөө чухал хууль хэлэлцэж байгаа учраас ингээд гишүүд идэвхтэй оролцоорой. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ. Гол нь бас нөгөө энд яг саналаа өгөөд байгаа гишүүддээ би баярлалаа гэж хэлж байна л даа.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “, дүү” гэсний дараа “төрлийн хүн, садангийн хүн” гэж нэмж, “гишүүдийн 3 хүртэлх гишүүнээс” гэснийг “3 гишүүнээс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Саранчулуун гишүүн асуултаа асууя. Чинбүрэн гишүүн бас асуултаа асууна гэж байна.

О.Саранчулуун: Би энийг ойлгохдоо төрлийн хүн, садангийн хүн, гэр бүлийн гишүүд гэж байгаа. Өнчин хүн байвал яах вэ гэсэн энийг л асууя.

Л.Энхнасан: 7 дугаар микрофон, ажлын хэсэг хариулна уу.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Өмнө, одоо мөрдөгдөж байгаа Донорын тухай хуульдаа яг 3 хүртэлх гишүүн гэдэг, яг алба байгуулагдсанаас хойш өнөөдөр бид бол яг практик дээр амьгүй донорын гэр бүлтэй уулзаад, донор болох хүсэлтээ тавьдаг. Ингэхэд бол нэлээн олон гишүүн хамгийн багадаа бол 5-аас 10 хүний бүрэлдэхүүнтэй орж ирж, нэг гэр бүлтэй уулзахад 2-оос хамгийн багадаа 3 удаагийн уулзалтыг хийдэг. Дээшээ бол 7, 8 удаагийн уулзалтуудыг хийдэг. Ингэж байж тухайн гэр бүлээс энэ донор болох зөвшөөрлөө бид авдаг байгаа. Мөн бас тухайн гэр бүл ч гэсэн татгалзах ийм эрхтэй байдаг. Одоо бол бид энэ заавал ч үгүй 3 гишүүн гэж томьёолсон нь болохоороо 1 дүгээрт яг энэ зөвшөөрлийнхөө процессыг илүү нарийн бататгаж байна гэсэн энэ санааг бол тусгасан байгаа. Яг өнөөдрийг хүртэлх яг энэ өнчин болон яг хамаатан садангүй ийм тохиолдол бол маш цөөн гарсан. Ямарваа нэгэн байдлаар дараа нь хаанаас ч юм гэнэт тухайн эмчлүүлэгчийн маань гэр бүлийн гишүүн гарч ирдэг учраас бид энэ 3 гишүүн гэдгийг хатуу заалтыг бол тавьж өгсөн байгаа.

Л.Энхнасан: Чинбүрэн гишүүн асуултаа асууна уу.

Ж.Чинбүрэн: Хуулийн төсөл бичихдээ бид 3 хүртэл гэдэг бичдэг нь бас ер нь гэр бүлийн гишүүдийн тоо хүрэхгүй бол яах вэ л гэж байгаа юм. 3 хүрэхгүй бол гарын үсгээ авч чадахгүй бол Батчулуун зөвлөх хүнд хийж болохгүй нь байна шүү дээ, авч болохгүй нь байна шүү дээ тийм ээ. Тэгэхлээр энийгээ яах юм? Ийм хатуу заалт байхлаар уг нь бидний санаа 3 хүртэл гэж байсан юм. Одоо нөгөө өнгөрсөн болсон процессоос болоод та бүхэн их болгоомжилж байна. Тийм айдас хүйдэстэй байна. Тэгтэл гэр бүлийн гишүүдийн тоо, гэр бүлийн гишүүд хэн бэ гэдгээ та хэд тодорхойлчихсон. Тэгээд энэ чинь тоондоо хүрэхгүй байвал бид яах вэ? Энэнд хариулаач.

Л.Энхнасан: Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Бидний энэ үйл ажиллагааны явцад нэг удаа ямар ч гэр бүлийн гишүүн байхгүй нэг донорын асуудал гарч байсан. Тэгээд бид бол эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд донор болгож авч чадаагүй. Яагаад гэвэл бид хэн нэгэн хүнээс зөвшөөрөл авах ямар нэгэн хүн байхгүй, холбогдох хүмүүс байхгүй байсан. Тэгээд хэрвээ бид тэгээд тэр хүнийг донор болгоод, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийчихсэний дараа ямар нэгэн байдлаар гэр бүлийн хүн тодорч гарч ирээд л, ингээд л бид зөвшөөрөхгүй байсан гээд л ингэвэл асуудал болдог. Тийм учраас нэгэнт бидэнтэй уулзаж учирч энэ зөвшөөрөл өгөх асуудал дээр хүн байхгүй бол бид донор болгохгүй. Ингээд харамсалтайгаар тэр боломжит донороо бид алдаж байсан тохиолдол байгаа.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн дарга энэ дээр. Энд яагаад жишээлбэл сая гишүүн 3 хүрэхгүй яах юм бэ гэж байна.

Б.Баярбаатар: Манай дэд ажлын хэсгүүд энэ хатуу 3 гишүүн гэдэг зүйлийг л оруулж ирсэн юм. 3 хүртэл гэж хуулийн анхны төсөл дээр байсан. Тэгэхдээ энэ амьгүй донороос эрхтэн шилжүүлэх зөвшөөрлийг авах нь өөрөө нэг талаараа хялбар байж болохгүй юм байна лээ, аягүй хэцүү. Тэгээд тухайн үед яг нөхцөл байдал дээр ар гэрийн хүмүүсийн сэтгэл зүйн асуудал, хэд хэдэн удаа, ер нь нэг өндөр ятгалгын түвшинд л явагдаж байж. Нас барж байгаа тархины үхлээр нас барж

байгаа хүн болгон бас донорын шаардлага хангахгүй, маш цөөхөн илэрдэг. Тэгээд 3 хүртэл гэдэг байх нь өөрөө яах вэ нэг хүнээс ч гэсэн авч болно л гэсэн үг байхгүй юу. Тийм. Энийг л хатуу 3 болгоё гэдэг л дэд ажлын хэсэг санал оруулж ирсэн юм. Энийг ажлын хэсгийн түвшиндээ дэмжээд л орж ирсэн байгаа. Байнгын хороо энийг 3 хүртлээр нь явж болно л доо.

Ер нь хуулийн концепцтойгоо бас зөрчилдөөд байгаа байхгүй юу. Энэ чинь бид амьгүй донорыг илрүүлэх ийм концепцтой шүү дээ, нэмэгдүүлэх. Тэртээ тэргүй бид жилд 3 мянган хүн тархины цус харвалтаар бурхны оронд одож байна шүү дээ. Тэгээд бидний нөгөө шашин шүтлэг, үзэл баримтлал, олон зүйлээс шалтгаалж ингээд энэ донор илрүүлэлт ингээд хойшоо суугаад байдаг. Гэтэл хууль дээрээ бид ингээд хатуу бас яг 3 гээд оруулчих нь бас нэг хаалт, яг хуулийнхаа үзэл баримтлалтай зөрчилдөөд байгаа зүйл энэ дээр ажиглагдаад байгаа юм. Ажлын хэсгийн даргын хувьд. Тэгэхээр 3 хүртэл гэдэг дээр нь, хүртэл гэдгээр нь оруулах нь зөв байж болно шүү. Энэ саналыг томьёолж аваад, тэгээд түрүүний нөгөө Наранбаяр гишүүний хураалгасан шиг дэмжээд явчихвал яах юм бэ, болж байна уу?

Л.Энхнасан: Яах вэ зүгээр энэ саналыг дэмжихгүй байхад л хуучнаараа үлдэнэ шүү дээ. Тийм. Тэгэхлээр саяын хэлснээр тийм энэ дэмжье гэсэн томьёоллыг хэрвээ дэмжихгүй бол гишүүдийн 3 хүртэл гишүүнээс гээд хуучнаараа л үлдэнэ гэж ойлгож байгаа юм. Зөв үү? Тийм байна. Тэгэхлээр. Тэгвэл ажлын хэсгийн даргын томьёолсноор өөрчлөлтийг оруулаад, эхний хэсэг нь бол хуучнаараа үлдээд, тэгээд гишүүдийн 3 хүртэлх гишүүнээс гэдгийг хуучнаар нь үлдээхээр тийм төслөөрөө үлдээхээр. Наранбаяр гишүүн саналаа хэлнэ үү.

П.Наранбаяр: Энэ дээр энэ 29 дүгээр санал байна. Тэгэхээр энэ дээр энэ найруулгын хувьд төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн дүү гэсний дараа төрлийн хүн, садны хүн гэж нэмэх гээд л болно гэсэн үг. Бусад нь хасагдана гэсэн үг. Тэгээд нэмэх гэсэн томьёоллоор санал хураалгах хүсэлтэй байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Саяын томьёоллоор санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “гадны нөлөөтэй” гэснийг “Гэмт хэргийн улмаас тархины үхэлтэй болох нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын” гэсний дараах “гишүүд” гэснийг “гишүүн, Улсын Ерөнхий прокурор” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6 дахь хэсэг нэмэх: Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хаана байна тэр нь? Уучлаарай.

“10.6.Амьгүй донорт насны хязгаар заахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Бид нөгөө донорынхоо насыг энэ хууль дээр хэд гэж тодорхойлж байгаа билээ гэдгийг нь эргээд асууя. Тэгэхээр энэ дээр нөгөө насны хязгаар заахгүй гээд харчихаар уншигдаж байгаа нь хэдэн ч настай хүн байж болох юм шиг уншигдаад байна л даа. Харин тийм. Тэгэхдээ энэ дээр амьгүй донорт насны

хязгаар заахгүй гэдэг энэ өгүүлбэр нь өөрөө хэдэн ч настай хүн байж болох. Өөрөөр хэлбэл хүүхэд байж болох юм шиг ингээд уншигдаад байна шүү дээ. Найруулгыг нь би яриад байгаа. Тэгэхээр энэ дээр тайлбар байж болох уу, эсвэл өөр хувилбар байж болох уу? Би зөв ойлгоод байна уу, эсвэл, энэ хүмүүс чинь энийг чинь ойлгох, хүүхэд юм байж болох юм уу гээд уншигдах гээд байна шүү дээ энэ чинь.

Л.Энхнасан: Тийм, ажлын хэсгийн дарга Баярбаатар дарга хариулна уу.

Б.Баярбаатар: Хуулийн төсөл хэлэлцэж эхлэх үеэс нэг амьгүй гэдэг үгэнд манай гишүүд нэг жоохон эмзэглээд асуугаад байх шиг байна. Амьгүй донор гэдгийг тогтоодог баг бүрэлдэхүүн бид түрүүн ярилаа шүү дээ. Тархины үхлийг яаж тогтоох вэ, ямар баг бүрэлдэхүүн ажиллах вэ гээд. Тэгэхээр энд насны хязгаар тогтоохгүй л гэж байгаа байхгүй юу. Болно л гэсэн үг амьгүй хүн чинь. Тэр чинь ямар янз бүрийн шалтгаанаар өвчин, гэнэтийн осол, гэмт хэрэг гээд янз бүрийн шалтгаанаар, янз бүрийн насны, янз бүрийн хүйсийн хүмүүс л орж ирнэ шүү дээ. Тэрийг нөгөө тодорхойлох баг нь тогтоогоод л, тэгээд цаашаа тэр амьгүй донорын юу руугаа л шилжиж байгаа юм л даа.

Л.Энхнасан: Тийм. Энэ дээр жоохон ажлын хэсгээр тодруулаад хэлчихсэн байх зөв байх л даа. Гэмт хэргийн юу бас орохгүй шүү дээ амьгүй донорт. Тодруулга Саранчулуун гишүүн. Хамгийн эхлээд ажлын хэсэг нэмж хариулъя гэж байна. Батчулуун зөвлөх 6 дугаар микрофон.

П.Батчулуун: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Манай энэ үйл ажиллагааны явцад амьдрал дээр ЭХЭМҮТ дээр хүүхдэд энэ тархины үхэлд хүрсэн тохиолдол бас хэд хэдэн удаа гарч байсан. Тэгээд бид мөн өмнөх хууль дээр бол нас заачихсан байдаг учраас бид бол энэ хүүхдэд амьгүй донор буюу хүүхдээс авсан эрхтнийг хүүхдэд шилжүүлэн суулгах энэ үйл ажиллагаа бол ингэж хаагдчихаад байсан учраас бид ингэж оруулж өгсөн юм. Ер нь дэлхийд бол өнөөдрийн практикт энэ насны хязгаар заахгүй байгаад байгаа. Учир нь юу гэхлээр өнөөдөр дэлхийн хамгийн өндөр настай амьгүй донор бол 95 настай хүн байгаа. 95 настай хүнээс элэг, зүрх, 2 бөөрийг нь аваад ингээд нийтдээ 4 хүнд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн байгаад л байгаа юм. Тэгэхлээр бол бид бол манай одоогийн хууль буюу эрхтэн шилжүүлэн суулгах багуудын удирдамж дээр 65 нас гээд заачихсан байдаг. Гэтэл бол 65 наснаас дээш настай боловч тухайн хүн нь амьдралынхаа явцад бол эрүүл саруул, өвчин зовлонгүй, тэгээд амьдралын хэв маяг нь сайн байсан улсуудын эрхтэн бол сайн, ямар нэгэн шинжилгээнд өөрчлөлт гарахгүй бол бид донор болгож болно л гэсэн санааг оруулж өгч байгаа. Учир нь гэвэл амьгүй донорын асуудал нэлээн хүнд байгаа учраас донорынхоо олдцыг нэмэгдүүлэх, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээгээ илүү олон болгох үүднээс энэ саналыг оруулсан юм.

Л.Энхнасан: Тодруулга Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Би энэ ажлын хэсгийн ажиллаж байгаа энэ маш чухал зорилго энэ тэрийг маш сайн ойлгож байгаа. Тэгээд маш их олон хүний амь насыг аврах гэж байгаа энэ төсөл учраас бас дэмжиж байгаа. Миний тодруулаад байгаа зүйл болохоор бид нөгөө донор болно гэдгээ өөрсдөө нэг урьдчилаад нөгөө хүмүүс чинь нөгөө и... концепц гээд зөвшөөрдөг шүү дээ. Тэгэхээр хүүхдэд тэгэх нөгөө боломж байхгүй, нас нь нөгөө үүсээгүй. Тэгэхээр ээж ааваас нь, эцэг эхээс нь ч юм уу зөвшөөрөл авна гэсэн үг үү гэдгийг л тодруулмаар байгаа байхгүй юу. Тийм,

тэгэхээр тэр процессыг энэ хуулийн аль хэсэгт орсон юм бэ? Зөвхөн ингээд заачихаар л тэр хэсэг нь орхигдчихсон юм шиг санагдаад тэгээд асуугаад байгаа шүү.

Л.Энхнасан: Нөгөө түрүүний 3 хүртэлх гээд. Тэгэхдээ ажлын хэсэг 7 дугаар микрофон хариулна.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Бид энэ хуулийн төсөл дээр хэд хэдэн донорын насны хязгааруудыг оруулж өгсөн байгаад байгаа. Эхний ээлжид яг өмнөх мөрдөгдөж байгаа амьд донорын насны хязгаар 21 нас хэвээр нь. Дараа нь энэ амьгүй донорын насны хязгаар дээр ямар нэгэн хязгаарлалт тавихгүй. Энэ нь бол ялангуяа хүүхдээс хүүхдэд эрхтэнд шилжүүлэн суулгах боломжийг нээж өгч байгаа. Мөн хуулийн заалт дээрээ хэрвээ амьгүй донор нь насанд хүрээгүй байвал эхлээд хүүхэд, дараа нь том хүн гэсэн энэ дарааллаар реципиент буюу эмчлүүлэгчийг сонгох дарааллыг мөн тусгаж өгсөн.

Мөн бид энэ эсийн донорын мөн насны хязгаарын асуудлыг гаргаж өгсөн. Ялангуяа энэ 18 хүрэхээрээ биологийн насны хувьд гүйцсэн байхад энийг бол энэ эсийн донор дээр ашиглаж болно гэдэг энэ, энэ зохицуулалтуудыг оруулж өгсөн. Зөвшөөрлийн хувьд бид амьд донороос орсон ч гэсэн амьд донорын тухайн гэр бүлийн гишүүдээс нь зөвшөөрлөө авдаг. Амьгүй донор болсон тохиолдолд гэр бүлийн 3 хүртэлх гишүүнээр гэсэн сая санал хураагдчихлаа. Ер нь хүүхэд байсан ч гэсэн заавал гэр бүлийн гишүүдээс нь зөвшөөрөл авч байж бид эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийгдэнэ. Донорын картын хувьд гэвэл насны хязгаар нь мэдээж 21 насаараа бол байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлийн гарчгийн “болохоо” гэснийг “болох хүсэлтээ” гэж өөрчилж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн энэ хуулийн 4.1.3-т заасан донор болох хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан гаргаж, донорын цахим үнэмлэх, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулж, донорын үнэмлэх авч болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн дугаарыг “11.3” болгон өөрчилж, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Татгалзах хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн дугаарыг “11.2” болгон өөрчилж, мөн хэсгийн “гэрчилгээ” гэснийг “үнэмлэх” гэж өөрчилж, мөн хэсгийн “татгалзах

эрхтэй.” гэсний өмнө “хугацаа хамаарахгүй” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “8.1-д заасан шаардлага хангасан амьд донороос эрхтэн, эд, эсийг авна” гэснийг “8.1, 8.2-т заасан шаардлага хангасан байна” гэж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан донороос авах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно” гэснийг “энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авна. Зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эс авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Асуулт, Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Уучлаарай манайхан, дахиад тодруулах хэрэгтэй. Эд, эрхтнийг авсны дараа эргүүлээд цогцсыг гэр бүлийнхэнд хүлээлгэж өгөхдөө өгөхтэй холбоотой ёс зүйн асуудал дээр ямар зохицуулалт энэ дээр байгаа юм бол гэдгийг тодруулах гээд байгаа юм. Яагаад гэхлээр орлуулаад юм уу, шингэнээр дүүргээд ч юм уу буцаагаад нөгөө ёслолд зориулж хүндэтгэлтэйгээр буцааж нөгөө цогцсыг гэр бүлд нь хүлээлгэж өгөх асуудал чинь маш том ёс зүйн асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ер нь ямар шинэчлэл хийсэн бэ? Энэ би ингээд нөгөө үзэж, үзэж байгаад л хамгийн холбоотой заалт нь энэ юм болов уу даа л гэж бодож тодруулж байгаа шүү.

Л.Энхнасан: 7 дугаар микрофон Алтантулга дарга.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Бид яг таны хэлсэнчлэн маш зүйтэй, яг энэ ялангуяа амьгүй донорын эрхтэн авсны дараа энэ цогцсыг хүлээлгэж өгөх энэ асуудлыг бол бид энэрэнгүй хүнлэг гэсэн энийг бол хуулийнхаа зарчим хэсэгтээ түлхүү оруулж өгсөн. Бид яг өнөөдрийн байдлаар хэрэгжиж байгаа бол бид гэр бүлд маш хүндэтгэлтэй, тухайн эрхтэн авах мэс засалд орсон бүх эмч, сувилагч нарыг үүдэнд нь жагсааж байгаад бүгдийг нь бөхийлгөөд хүндэтгээд, тухайн донортоо хүндэтгэл үзүүлээд, ингээд түр хадгалах, цогцос түр хадгалах өрөө рүү бид хүлээлгэж өгдөг. Ингээд холбогдох маягтдаа гэр бүлдээ цогцсоо хүлээлгэж өгсөн гэсэн маягт дээр гарын үсэг зуруулаад, яг манай ийм, ийм хүнд, ингэж, ингэж бид та бүхний зөвшөөрсний дагуу энэ, энэ эд, эрхтнийг ингэж, ингэж авлаа шүү гэдгийг бүрэн танилцуулаад, шаардлагатай бол дүрсээр мөн баримтжуулж үүнийг танилцуулаад, ингээд гэр бүлд бүрэн хүлээлгэж өгдөг байгаа. Мөн оршуулгын асуудлыг мөн адил бид энэ асуудалд оруулж өгсөн. Ялангуяа амьгүй донорын гэр бүлд энэ оршуулгын тэтгэмж өгөх асуудлаа мөн энэ хуулийн төсөлдөө бол тусгаж өгсөн байгаа.

Л.Энхнасан: Саранчулуун гишүүн тодруулга.

О.Саранчулуун: Маш их баярлалаа. Тайлбарлавал нөгөө харагдах байдал косметик тэр эд, эрхтнийг авсна дараах цогцсыг буцаагаад бүрэн бүтэн болгох ийм оршуулах ёслолд бэлдэхтэй холбоотой зохицуулалтыг асууж байгаа шүү бас давхар.

Л.Энхнасан: 7 дугаар микрофон процессыг нь асуугаад байна л даа. Тэгээд илүү нарийвчлаад яриад.

Б.Алтантулга: Эрхтэн авах мэс заслын дараа бол бид яг гэр бүлийн гишүүнд хүлээлгэж өгөхдөө маш хүндэтгэлтэй ингэж ханддаг. Тэр ч үүднээсээ бол яг багууд

тухайн эрхтэн авсан гэхээрээ бид энэ цогцос гэж нэрлээд байгаа, энэ цогцсоо хэвлийд нэмэх зүслэг хийж байгаа бол үүнийг бид косметик оёдол тавьж ингэж бүрэн хаагаад, ямарваа нэгэн илүүдэл цус, шингэн ч гэдэг юм уу эдгээр бүх зүйлийг цэвэрлээд, бүрэн цэвэрхэн ийм хүндэтгэлтэй байдалд оруулж ингэж оруулдаг байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээг үзүүлнэ” гэснийг “үйл ажиллагааг зохицуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн, зохион байгуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрлийн дагуу энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагын эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэргэжлийн баг эрхтэн, эд, эс авах эмнэлгийн тусламж үйлчилгээг гүйцэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “донороос” гэснийг “донорыг бүртгэх,” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “хадгалах,” гэсний дараа “хамгаалах,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн дугаарыг “12.3” болгож, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Энэ хуулийн 11.1-д заасан амьгүй донороос эрхтэн, эд, эс авахдаа гэр бүлийн 3 гишүүнд урьдчилан танилцуулах бөгөөд энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авахгүй.” Санал гарсан ажлын хэсэг, энэ түрүүний 3-д тийм. 3 гишүүн, нөгөө түрүүний зааснаар нөгөө яг өөрчлөн найруулаад 3 хүртэлх 3 хүртэлх гишүүнээс урьдчилан танилцуулах бөгөөд гээд тийм энэ өөрчлөлтөө хийгээд, дэмжихээр санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Эрхтэн, эд, эс шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах” гэснийг “Био банк байгуулах, ашиглах үйл ажиллагаа” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь үндэсний хэмжээнд оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зориулалттай нэгдсэн био банкттай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 13.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэх” гэснийг “Био банк байгуулах, ашиглах” гэж, мөн хэсгийн “байгууллагын саналыг үндэслэн” гэсний өмнөх “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.3, 13.4 дэх хэсэг нэмэх:

“13.3.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага нь эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх био банктай байж болно.

13.4.Био банкиг эд, эсийг цуглуулах, шинжлэх, өсгөвөрлөх, боловсруулах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, устгах, шаардлагатай үед эмчилгээ, судалгааны зорилгоор тохирох эд, эсээр реципиент эмнэлэг болон судалгаа, шинжилгээний байгууллагыг хангах зориулалтаар ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шаардлага хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “импортолж болно” гэсний өмнө “энэ хуулийн 14.3-т заасан журамд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийг хасах:

“15.1.энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага нь донор, реципиентийн эрхтэн, эд, эсийн тохироог үзэх, донороос авсан эрхтэн, эд, эсийг шинжлэх, боловсруулах, шилжүүлэн суулгах мэс засал, эмчилгээг гүйцэтгэх мэргэжлийн багтай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 15.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “13.3-д” гэснийг “12.5-д” гэж, мөн зүйлийн 15.8 дахь хэсгийн “Донор бэлгийн эсийг” гэснийг “Бэлгийн эсийг” гэж, мөн хэсгийн “болох бөгөөд холбогдох журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.” гэснийг “болно.” гэж, мөн зүйлийн 15.9 дэх хэсгийн “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага эрхэлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4-т заасан эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэж болно.” тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.10, 15.11 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“15.10.холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрөх бөгөөд бусад тохиолдолд тээгч эх ашиглахыг хориглоно.

15.11.Бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэ хуулийн 12.5-д заасан журмыг баримтлах бөгөөд талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн нэг удаагийн амьд төрөлтөд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “байх бөгөөд мэдээллийн аюулгүй байдал технологийн нууцлал, найдвартай байдлыг хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 16.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн” гэснийг “эрүүл мэндийн байгууллага” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

51.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “ажиллагааг зохион байгуулах,” гэснийг “ажиллагаа,” гэж өөрчилж, мөн зүйлийн 18.1.3, 18.1.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.4 дэх заалт болгон шилжүүлж, мөн заалтын “4.1.8-д заасан” гэсний өмнө “4.1.7,” гэж нэмж, мөн заалтын “механизм” гэснийг “систем” гэж өөрчилж, мөн заалтын “эмнэлгийн мэргэжилтнийг” гэсний өмнөх “эмч,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ. 50-ийг уншаагүй байна.

50.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шилжүүлэн суулгах” гэсний дараа “тусламж, үйлчилгээний” гэж, мөн заалтын “баримтлах бодлого,” гэсний дараа “төлөвлөлт, арга хэмжээ,” гэж тус тус нэмж, мөн заалтын “төрөөс” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

53.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.5.энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг батлах, хэрэгжилтийг хянах, цуцлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“12.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.1 дэх хэсэг нэмэх:

“19.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан тусгай мэргэжлийн төв байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Эрүүл мэндийн тухай хуульд заасан тусгай мэргэжлийн төв гэдэг нь одоо ямар бүтэцтэй байгууллагыг хэлж байгаа вэ гэдгийг тодруулъя. Тэгээд дотроо хэдэн хүнтэй, хэдэн багтай, ямар хүчин чадавх чадалтай ийм байгууллагыг хэлдэг юм бэ гэдгийг тодруулж өгөөч?

Л.Энхнасан: Ажлын хэсэг 5 дугаар микрофон.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. ТНБД Эрдэнэбаяр. Бид бас энэ байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудал дээр нэлээн олон талаас нь харж, олон улсын туршлагуудыг судалсан байж байгаа. Ялангуяа олон улсад байгаа жишиг тогтолцоогоор агентлагийн бүтэцтэй, яамны дотор бас байдаг газар, хэлтэс гэдэг юм уу ийм бүтэц зохион байгуулалт, мөн үндэсний төв болон энэ асуудлыг эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлыг зохицуулах ийм байгууллагууд гэсэн ийм олон хэлбэрүүдээр явж байгаа. Энэ бол бас тухайн улсын эрүүл мэндийн тогтолцооны онцлог, мөн энэ дээр хийгдэж байгаа тусламж, үйлчилгээний онцлогтойгоо уялдаж ингэж явж байгаа.

Манайд байгаа эрүүл мэндийн хөгжлийн төв дотор яг харьяанд ажиллаж байгаа энэ эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгадаг зохицуулах алба маань ер нь цаашдаа өргөжөөд, энэ дээр энэ тусгай мэргэжлийн төв гэдэг энэ статусаар ажиллах нь яг хийгдэж байгаа үйл ажиллагаатайгаа холбоотойгоо илүү зохимжтой юм байна. Яагаад гэхээр энэ хүмүүс маань очиж нөгөө донортой уулзахаас өгсүүлээд бүүр дараагийн бүх үйл ажиллагаанууд дээр ингэж оролцож, эмнэлгүүдтэйгээ зайлшгүй хамтарч ажиллаж байгаа. Тийм учраас энэ хийгдэж байгаа функцүүдийн хувьд энэ саяын миний олон улсад байгаа жишгүүдийг ер нь агуулсан байдлаар явж байна. Монгол Улсынхаа онцлогтой бид уялдуулаад үзэхээр энэ тусгай мэргэжлийн төв байх нь илүү зохимжтой юм байна.

Тусгай мэргэжлийн төв гэдэг нь Эрүүл мэндийн тухай хууль дээр улсын хэмжээнд үндсэн эсвэл төрөлжсөн нэг мэргэжлээр лавлагаа тусламж, үйлчилгээг амбулаториор үзүүлж, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх бөгөөд эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана гэсэн ийм ерөнхий байдлаар тусгасан байдаг. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад яг ЭМЯ-ны харьяанд 3 тусгай мэргэжлийн төв байгаа. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон Эмгэг судлалын үндэсний төв гэсэн ийм яг төрөлжсөн чиглэлээрээ үйл ажиллагаа явуулдаг ийм байгууллага байгаа. Тэгэхээр эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах энэ үйл ажиллагаагаа бид яг ийм төрөлжсөн чиглэлээрээ ингэж хийж явах нь өнөөдрийн бидний яг явж байгаа үйл ажиллагаатай зохицох юм байна гэдэг байдлаар харж байгаа.

Л.Энхнасан: Тодруулга Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгэхлээр Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан нэг агентлагтай болно гэсэн үг үү? Энгийн үгээр.

Л.Энхнасан: Энийг нэлээн ажлын хэсэг дээрээ ярьсан юм. Тэгээд ажлын хэсгийн дарга Баярбаатар гишүүн хариулна уу.

Б.Баярбаатар: Анх өргөн баригдсан хуулийн төсөл дээр агентлагийн түвшинд орж ирсэн. Тэгээд ЭМЯ-ныхантайгаа ярьж байгаад ЭМЯ-ны бүтэц дотор энэ тусгай мэргэжлийн төв болгоё гэх нь илүү хялбар, үйл ажиллагаа явуулахад саадгүй. Өнөөдөр жишээлбэл бид агентлагийн түвшинд явуулъя гэхээр энэ хууль батлагдсан өдрөөсөө мөрдөгдөж эхэлнэ гэж үзэхэд ирэх жил бид агентлагийг нь байгуулах буюу төсөвт суулгаж байж агентлагийн асуудал орж ирэх. Тэгэхээр нөгөө хуулийн хэрэгжилт маань хойшоо татагдах нөхцөл байдал руу орж байгаа учраас ЭМЯ-ны ТНБД Эрдэнэбаяр даргын хэлж байгаатай адилхан яг мэргэжлийн тусгай төв гэдгээр явах нь зөв. Бусад улсын жишгийг Солонгос жишээлбэл агентлаг байдаг. Яваандаа бид энэ асуудлыг агентлагийн түвшинд үйл ажиллагааг нь нэмэгдүүлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх ийм боломж байгаа гэж харж байгаа.

Л.Энхнасан: Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Ерөөсөө энэ хуулийн бас нэг том цөм нь энэ байгаа. Яаж удирдах юм бэ, Монгол Улсад үндэсний хэмжээнд эрхтэн олдлоо гэхэд амьгүй донор эрхтнүүдээ зөв хуваарилж байна уу, хэн нэгнийг алагчилж байна уу, ил тод байдлаа хангаж чадаж байна уу, үнэхээр шаардлагатай хүмүүс эрхтэн авч чадаж байна уу гэдэг өөрөө асуудал нь энэ хуулийн амин сүнс нь. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бид яалт ч байхгүй энэ төвлөрсөн удирдлага хийхгүй бол энэ систем өөрөө амь орохгүй. Нэг ёсондоо систем задрах, олон байгууллага дотор тодорхойгүй байдал одоо хэр нь бас байж л байгаа. Тийм учраас энийг засах зорилгоор нэг удирдлагатай систем зохион байгуулъя гэж байгаа. Харин сая энэ хуульд би бол угаасаа шууд агентлаг гэж байсан. Тэгэхлээр 2 шатлалтай Баярбаатар даргын ажлын хэсэг ингэж оруулж ирсэн. Энэ магадгүй зөв ч байж магадгүй. Үе шаттай бид ингээд үечлээд, дараа нь аажимдаа нөгөө амьгүй донорын тоо ихсэх, технологи улам сайжрах үед агентлаг болоод биеэ даагаад явах нь зөв байж магадгүй л гэж харж байна.

Л.Энхнасан: Тодруулга Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Маш чухал асуудал учраас хүмүүс мэдээсэй гэж үзээд асууж тодруулж байна. Тэгэхлээр хэрвээ тусгай мэргэжлийн төвтэй болно энэ бие даасан ийм төвийн тухай хуультай байх уу, дагалдах хууль гарах уу гэдэг нэг бүтцийн талаасаа болон эрүүл мэндийн даатгал бусад үйлчилгээтэй холбоотой хууль байх уу гэдэг тодруулга байгаа?

2-т гэвэл хэрвээ бие даасан төв нэгэнт бид яваандаа шилжиж ярьж байгаа бол сургалтын асуудлыг ер нь хөндөх болов уу гээд дахиад асуучихъя.

Л.Энхнасан: 5 дугаар микрофон Төрийн нарийн.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тийм, ер нь энэ дээр бид ажлын хэсэг дээрээ нэлээн ярилцсан байж байгаа. Эрүүл мэндийн тухай

хууль дээрээ энд нэг заалт тэр нөгөө яг жагсаагаад биччихсэн байгаа энэ дээр нэг заалт оруулчихад л ерөөсөө болох юм. Тэгэхээр энэ хууль батлагдах үе дээр 1 дүгээрт нь бид нэмэлт, хууль дагаж гарах энэ Эрүүл мэндийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт байдлаар тусгаж болно.

Ер нь ЭМЯ-наас нэлээн олон хуулиудыг энэ жил шинэчлэн найруулах, энэ дээр нэлээн ажиллаж байгаа. Энэ дээр Эрүүл мэндийн тухай хууль бас орчихсон явж байгаа. Тэгэхээр аль аль талаас нь бид хараад, энийг ингээд яг ямар нэгэн зөрчилгүйгээр зохицуулаад явах боломжтой гэж харж байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “12.5-д” гэснийг “12.5. 13.2-т” гэж, мөн зүйлийн 19.1.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “эмчилгээ,” гэснийг “тусламж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 19.1.4, 19.2.3, 19.3.4 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Горимын санал Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Уучлаарай сая дарсан чинь арай хоцорчхов уу яав, дахиж санал хураалгаж өгөхгүй юу.

Л.Энхнасан: Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. Саяын санал хураалт дэмжигдэж, хүчингүй боллоо. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ, хүчингүй боллоо. Ингээд дахиад санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 гишүүнээр, 61,1 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийн дарга өлсөөд ч бас юу яаж эхэлж байна шүү.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалтын “эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхыг дээшлүүлэх,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.2.3 дахь хэсэг нэмэх:

“19.2.3.эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхыг дээшлүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Саяын санал хураалтыг цуцалъя. Саранчулуун гишүүн асуултаа асууна.

О.Саранчулуун: Би түрүүн нөгөө сургалтыг би 2 заалт дээр асуусан шүү дээ. Сургалтын хэсгийг ер нь яаж уялдуулах вэ гээд байгаа. Гэтэл одоо энэ дээр нөгөө чадавхжуулах, дээшлүүлэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ сургалтдаа орох уу, яах билээ гэдгийг тодруулчихъя?

Л.Энхнасан: Ажлын хэсэг 7 дугаар микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. 19 дүгээр зүйлийн хэсэг нь болохлоороо яг манай үйл ажиллагааны эрх, үүргийн асуудал байгаа. Тэгээд тэр дундаа бид яг энэ 19.2.3 дахь заалт дээрээ эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах багийг чадавхыг дээшлүүлэх гэж оруулсан. Энэний тайлбар нь ерөнхийдөө бол яг сургалтын бүх үйл ажиллагаагаа оруулсан байгаа. Тэгэхээр яг манай албаны зүгээс нийт энэ эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа реципиент эмнэлэг,

эрхтэн шилжүүлэн суулгах багууд, нөгөө талдаа амьгүй донорыг илрүүлж байгаа донор, эрүүл мэндийн байгууллагын нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар, сургалт энэ үйл ажиллагааг зохион байгуулна гэж оруулж өгч байгаа.

Дараагийн багийн чадавхыг дээшлүүлэх гэдэг өнөөдрийн байдлаар Монгол Улсад эмчлэгдэх, оношлох боломжгүй өвчний жагсаалтад манай элэг, бөөр шилжүүлэн суулгах үйл ажиллагааны асуудлууд орсон байдаг. Энэ ч үүднээсээ энэ асуудал дээрээ нэг талдаа зочин профессорыг эх орондоо урьж сургалт судалгааны ажлуудыгаа хамтарч хийе, энэ үйл ажиллагаагаа зохион байгуулъя гэсэн үүднээсээ энэ заалтыг оруулсан байгаа.

Л.Энхнасан: Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн” гэсний дараах “15.1.4, 15.1.5,” гэснийг, мөн заалтын “15.1.13-т заасан” гэсний өмнөх “15.1.12,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.1 дэх заалтын “донор эмнэлгийн,” гэснийг хасаж, мөн заалтын “ёс зүйн хороодтой” гэсний өмнө “мэргэжил,” гэж нэмж, мөн зүйлийн 19.4.2 дахь заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх” гэснийг “шийдвэрлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн,” гэснийг, мөн хэсгийн “байгууллагын бүтцэд” гэсний өмнөх “байгууллага байх ба тус” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “4.1.6” гэснийг “4.1.7” гэж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “мэдээлнэ.” гэснийг “мэдээлж, улирал тутам тайлагнана.” гэж тус тус өөрчилж, “донорын талаарх мэдээллийг” гэсний өмнөх “амьд, амьгүй” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ. Эрдэнэбат гишүүнийг дэмжсэнээр тооцъё.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дахь заалтын “хүндрэл, сөрөг нөлөөллөөс” гэснийг “эрсдэл, хүндрэлээс” гэж, мөн зүйлийн 20.2.2 дахь заалтын “энэ хуулийн 20-д” гэснийг “энэ хуулийн 19-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.3.6 дахь заалтын “эрчимт эмчилгээг” гэсний өмнө “амин чухал эрхтний үйл ажиллагааг дэмжин,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.3.8 дахь заалт тус тус нэмэх:

“20.3.8.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд дараах үйл ажиллагааг хориглоно:

21.1.1.донор болон реципиент, тэдний гэр бүлийн гишүүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээдээс аливаа хэлбэрээр урамшуулал, шан харамж авах;

21.1.2.албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох;

21.1.3.Шинжлэх ухааны бус зорилгоор судалгаа, шинжилгээ, туршилт хийх;

21.1.4.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл.Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

22.3.Хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх гэдэг нь өмнө нь байснаасаа ямар ялгаатай юм бэ? Хэр ахиц гарч байгаа гэдгийг тодруулъя.

2-т гэвэл 22.2 дээр Амьд донорт үзүүлж байгаа эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журам дээр өмнө нь байгаагаасаа ямар ахиц өөрчлөлт гаргах вэ гэдгийг тодруулж өгөөч?

Л.Энхнасан: Ажлын хэсгийн гишүүн Эрдэнэбат гишүүн хариулна уу. Эрдэнэбат гишүүний микрофоныг нээнэ үү.

С.Эрдэнэбат: Даатгал төлж байгаагаас үл хамаараад 4 сая 500 мянган төгрөг болгосон байна лээ. Гэхдээ энийг даатгал төлсөн, төлөөгүй гэдэг байдлаар биш, ер нь бол нөгөө оршуулгын дундаж зардлыг аваад үзвэл хамгийн доод тал нь өнөөдөр нэг дундаж оршуулгын зардал 10 сая төгрөгийн багцтай байна лээ. Тийм учраас энийг одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг буюу жил болгон индексэждэг байдлаар нь шийдээд явъя гэдэг үүднээс нь 10 сая, 10 дахин болгож нэмэгдүүлсэн. Ингэснээрээ 4,5 сая 8 сая хоёрын хооронд 3 сая орчим төгрөгийн зөрөө байгаа. Гэхдээ энийг тэр даатгал төлсөн, төлөөгүйтэй огт холбож болохгүй.

Даатгалтай, даатгалгүй байхад нь тэрийг үл асуугаад тэр хүнээс амьд бус донорынх нь эд, эрхтнийг авч байгаагийнх нь төлөө тэр хүнийг хүн ёсных нь дагуу оршуулахад нь ар гэр болон үлдэж байгаа хүмүүст нь олгож байгаа тэтгэмж гэдэг байдлаар нь өгч байгаа.

Оршуулгын зардлуудтай даатгалын сангаас олгож байгаа оршуулгын зардалтай давхцах гэдэг асуудал тэр бүүр өөр ойлголт шүү. Тийм. Тэрэнтэй давхцаад авна уу, эсхүл даатгал төлдөггүй нь авахгүй байна уу огт хамаа байхгүй. Энийг 4,5 саяыг шууд 7 сая 920 мянган төгрөг болгоё, цаашдаа нэмэгдээд явна гэдэг.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс бас нэмж хариулаад, ер нь хэчнээн хүн энэ тэтгэмжийг авсан, үүнтэй холбоотой хэчнээн зардал гарах вэ гээд. Энэ бас гишүүдэд мэдээлэл өгөх нь чухал байх. 7 дугаар микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдрийн байдлаар яг манай алба 18 онд байгуулагдсанаас хойш, мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс энэ амьгүй донорын гэр бүлд оршуулгын тэтгэмж өгдөг энэ тогтоол батлагдсанаас хойш бол яг даатгал төлөгч биш байсан тохиолдолд Эрүүл мэндийн дэмжих сангаас 2023 онд 1 тохиолдол байна. Бусад тохиолдол нь даатгал төлсөн тохиолдол буюу халамжийн сангаас 2023 онд 1 тохиолдол, 2024 онд 4 тохиолдол, 2025 онд донор гараагүйтэй холбоотой энэ тохиолдол байхгүй. 2026 онд 1 тохиолдол. Нийт бол 22 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг олгосон байна. Одоо бол бид ажлын хэсгээр ярилцаад ер нь жилд хамгийн лимит нь бид дунджаар 10 донор гарах боломжтой гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ бол нэг их тийм төсөвт бол тийм ч айхтар ачаа болохгүй байх гэж үзэж байгаа юм.

Л.Энхнасан: 2 дахь нь ажлын хэсгийн дарга Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Тийм амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээ хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд хөнгөлөлттэй амрахыг нь Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд журам батална гэж байгаа. Тэгэхээр энэ журмаа жил болгон сайжруулаад явдаг юм байна лээ. Энэ хууль батлагдсаны дараа дагаж гарах, одоо бас өнөөдөр ч мөрдөгдөж байгаа журам. Тэгэхдээ үнэ тарифтай холбоотой асуудлууд дээр манай энэ 2 хуулийн ажлын хэсэг саналаа нэгтгээд өгчихсөн байгаа. Жишээлбэл ЗГ-аас тогтоосон жишиг үнэ гэх юм уу, нөгөө рашаан сувилал улсаас олгож байгаа мөнгөө бид аль болох нөгөө донорууддаа ингээд хүртээмжтэй, жигд байх ийм боломжийг нь энэ журмаар зохицуулъя гэдэг байдлаар гаргаж өгсөн байж байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 24 дүгээр зүйлийг 23 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл. Санхүүжилтийн тогтолцоо

23.1. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, реципиентийн төлөх төлбөр,

хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

23.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасны дагуу тогтооно.

23.4.Дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцах бөгөөд худалдан авалт, тасралтгүй бэлэн байдал, хуваарилалт, хяналтын асуудлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулна.

23.5.Хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.11-т заасны дагуу шийдвэрлэнэ.” Асуулт асууна, Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Реципиентийн төлөх төлбөр дээр ямар зохицуулалт байх юм бэ? Энэ дээр ер нь ямар урьдчилсан байдлаар ямаршуу зохицуулалтыг төсөөлж байгаа вэ, эсвэл гаргачихсан байгаа юу энэ дээр мэдээлэл өгөөч?

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 7 дугаар микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Реципиентийн төлөх төлбөр гэдгээр эмчлүүлэгчийн эрхтэнд шилжүүлэн суулгах тохиолдолд төлж байгаа төлбөр гэсэн үг. Энэ нь одоо бол ЭМД-ын сангаас тодорхой хэмжээний хөнгөлөлттэй. Хэрвээ ажил олгогч байвал хамтын төлбөрийг бол нэмж төлдөг энэ төлбөрийг бид энэ заалтдаа бол оруулж өгсөн байгаа. Бусад тохиолдол бол хавдар оношлогдсон эсвэл группт байдаг бол ЭМД-ын сангаас хөнгөлж байгаа. 100 хувь хөнгөлж байгаа.

Л.Энхнасан: Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Найруулгын санал. 1.Төслийн 4 дүгээр зүйлийн, энийгээ хураах уу? Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтын “аав, ээжийг” гэснийг “эцэг, эхийг” гэж, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “суулгах” гэснийг “суулгуулах” гэж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “доор дурдсан” гэснийг “дараах” гэж, төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “шаардлагад нийцсэн” гэснийг “шаардлага хангасан” гэж тус тус өөрчлөх;

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтын “эрүүл мэндийн байгууллага” гэсний өмнөх “заасан” гэснийг, төслийн 15 дугаар зүйлийн 15.11 дэх хэсгийн “холбоотой тусламж, үйлчилгээг” гэсний дараах “үйлчилгээг” гэснийг, төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын “эрхтэн,” гэсний өмнө, энэ чинь болохгүй, хасагдаж байгаа хүнийх гэж байхгүй юм чинь, энийг хасаад, төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “талаарх” гэснийг, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын

“ухуулан” гэснийг тус тус хасах. Энэ тусдаа юм уу? Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Одоо хамгийн, 64. Ажлын хэсгээс гарсан санал байна. Зарчмын зөрүүтэй 64 дүгээр санал дэмжигдсэнтэй холбогдуулан Хуулийг даган мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ. Үгүй хураагдахгүй. Тэгэхлээр одоо, толгойноос.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаар, хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дугаарыг “2” болгож, мөн заалтын 6.19 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын дугаарыг “1” болгож, мөн заалтын 6.1.4 дэх заалтын “, холбогдох баримт бичиг” гэснийг “болон хоорондын байгуулсан гэрээ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Хоёр.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл тус тус нэмж, төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалтын “Донорын тухай хуулийн 3.1.2, 3.1.4-т” гэснийг “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.5-д” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн танилцуулна. Болохгүй шүү дээ, хэн? Баярбаатар гишүүн танилцуулна, уучлаарай. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА